



Нээлттэй Нийгэм  
Форум



Сонгогчдын  
Боловсролын Төв



Глоб  
Интернешнл

□ 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит  
ажлын санхүүжилтийн мониторинг□

**ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ**  
**2004**

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү тайланг хэсэгчлэн болон бүтнээр нь  
дахин хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар  
хандаж зохих зөвшөөрөл авна.

# **ГАРЧИГ**

## **ТОВЧ АГУУЛГА**

<b>I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА . . . . .</b>	
1.1.    Мониторингийн зорилго ба зорилтууд	7
1.2.    Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд урвуулан ашиглах	7
1.3.    Төслийн зохион байгуулалт	9
<b>II. МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ . . . . .</b>	
2.1.    Сонгуулийн арга хэмжээний мониторинг	11
2.2.    Хэвлэл мэдээллийн мониторинг	13
2.3.    Төрийн эх үүсвэрийг ашигласан санхүүгийн тооцоог гаргасан аргачлал	17
<b>III. ХҮУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН . . . . .</b>	
3.1.    Хууль тогтоомжийн заалтууд	21
3.2.    Хууль тогтоомжийн зөрчилд хүлээлгэх хариуцлага	24
3.3.    Хууль тогтоомжийн хэрэгжилт	26
<b>IV. УЛС ТӨРИЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ . . . . .</b>	
4.1.    Улс төрийн орчин	30
4.2.    2004 оны УИХ-ын сонгуулийн кампанитажлын төлөв байдал	31
4.3.    Бусад байгууллагын мониторинг	32
<b>V. МОНИТОРИНГИЙН ДҮН . . . . .</b>	
5.1.    Сонгуулийн арга хэмжээний мониторинг	33
5.2.    Хэвлэл мэдээллийн мониторинг	40
5.3.    Хуулийн хэрэгжилт	47
5.4.    Санхүүгийн тооцоо, үр нөлөө	50
<b>VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ . . . . .</b>	
6.1.    Товч дүгнэлт	58
6.2.    Төрийн эх үүсвэрийг урвуугаар ашигласан хүчин зүйл	59
6.3.    Зөвлөмж	60

## ТОВЧИЛСОН НЭР

УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТХ	Сонгуулийн тойргийн хороо
СТСХ	Сонгуулийн тойргийн салбар хороо
CXX	Сонгуулийн хэсгийн хороо
НДХ	Нутаг дэвсгэрийн хороо
ЭОА	Эх орон-Ардчилал эвсэл
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн Нам
МЭНН	Монголын Эв Нэгдлийн Нам
МНН	Монголын Ногоон Нам
МЛН	Монголын Либериал Нам
БНН	Бүгд Найрамдах Нам
РТХЭГ	Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
MYTV	Монголын үндэсний телевиз
MYP	Монголын үндэсний радио
UBS	Ulaanbaatar Broadcasting System

## **ТОВЧ АГУУЛГА**

Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглах, хэвлэл мэдээллийн тэнцвэргүй байдалд мониторинг хийх зорилгоор “2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүжилтийн мониторинг” төслийг Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын Боловсрол Төв болон Глоб Интернэйшнл зэрэг төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүллээ.

Үг мониторингийг сонгуулийн кампанит ажлын хуулиар тогтоосон хугацаанд буюу 2004 оны 4 дүгээр сарын 26-наас 2004 оны 6 дугаар сарын 26-ны хооронд хийлээ. Мониторингийн хүрээнд сонгуулийн арга хэмжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн нам, нэр дэвшигчдийн талаар явуулсан мэдээлэлд мониторинг хийн, илрүүлсэн тоо баримтууд дээр анализ дүгнэлт хийн, сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэр ашиглахыг зогсооход чиглэгдсэн шинэчлэл хийх талаар санал зөвлөмж боловсруулан гаргасан. Түүнчлэн, урвуугаар ашиглагдсан төрийн эх үүсвэр болон сонгуулийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоог гаргасан ба төрийн эх үүсвэрийг улс төрийн зорилгод ашиглахын хор холбогдлын талаар иргэдийн ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаа явууллаа.

### **Мониторингийн дүнг тоймлон харуулвал:**

Сонгуулийн арга хэмжээ. Нийт 556 арга хэмжээ хамрагдан төрийн өмчийн байрыг үнэгүй ашигласан байдалд мониторинг хийсэн. Нийт төрийн өмчийн байрыг үнэгүй ашигласан байдлыг намуудаар авч үзвэл 80 хувь нь MAXH, 20 хувь нь Эх орон-Ардчилал эвсэл байна. Арга хэмжээнд ашигласан төрийн унааны 98 хувь нь MAXH, 2 хувь нь Эх орон-Ардчилал эвсэл байна. Төрийн албан хаагч ашигласан байдлын 99 хувь нь MAXH-ын арга хэмжээнд, 1 хувь нь Эх орон-Ардчилал эвслийн арга хэмжээнд хамаарч байна. Ажигласан 556 арга хэмжээний зардлыг жишиг болгон авч, урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийг үндэсний хэмжээнд буюу 76 тойротг тооцоолон мөнгөн дүнгээр илэрхийлбэл нийт 1,393,034,400 төгрөг болж байгаа ба намаар харуулбал MAXH 1,239,958,240 төгрөг, Эх орон-Ардчилал эвсэл 153,076,160 төгрөг болж байна.

**Төрийн өмчийн хэвлэл мэдээлэл.** Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн сурталчилгаанд их хэмжээгээр ашиглагдсан байна. Энэхүү төрийн хэвлэл мэдээллийн эх үүсвэрийг урвуулан ашигласан санхүүгийн тооцоог гаргавал 1,764,400,000 төгрөг болж байгаа ба 96% нь MAXH, 2,3% нь Эх орон-Ардчилал эвсэл, 1,7 % нь бусад нам, нэр дэвшигчдэд оногдож байна.

**Сонгуулийн төлбөртэй сурталчилгаа.** Телевизийн нийт төлбөртэй сурталчилгааны MAXH 56,4%, “Эх орон-Ардчилал” эвсэл 31,1%, бусад нам

11,5%, бие даан нэр дэвшигч 1,1% байна. Радиогийн хувьд MAXH 58,3%, “Эх орон–Ардчилал” эвсэл 28,7%, бусад нам 12,5%, бие даан нэр дэвшигч 0,6 % байна. Мониторингт хамрагдсан нийт сонины хувьд MAXH 73,1 %, “Эх орон –Ардчилал” эвсэл 22,4 %, бусад нам 4,2% төлбөртэй сурталчилгаа эзэлж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан намуудын сонгуулийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоог гаргавал MAXH 656,4 сая төгрөг, “Эх орон–Ардчилал” Эвсэл 304,9 сая төгрөг, бусад нам 166,3 сая төгрөг, бие даан нэр дэвшигчид 12,5 сая төгрөг, нийтдээ 1140,1 сая төгрөг болж байна. Үүнийг намуудын СЕХ-нд өгсөн санхүүжилтийн тайлантай харьцуулахад “Эх орон–Ардчилал” Эвсэл 1,531,232 төгрөг, MAXH 785287,5 төгрөгийн зөрүүтэй байна.

2004 оны УИХ-ын сонгуулиар нийт урвуулан ашиглагдсан төрийн эх үүсвэрийн мөнгөн дүнгээр илэрхийлбэл 3 тэрбум 157,7 сая төгрөг болж байна. Эдгээр дүнг намаар харуулбал MAXH 2,935,058,240 төгрөг, Эх Орон–Ардчилал 195,176,160 төгрөг болж байна.

Мониторингийн явцад илэрсэн зөрчил, тулгамдсан асуудлыг дүгнэн үзэхэд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах нь аливаа нэг намын буруутай үйлдэл гэхээсээ илүү ийм боломж бүрдүүлж буй хууль эрх зүйн болон тогтолцооны гажуудлыг харуулж байна. Өөрөөр хэлбэл үр нөлөөтэй хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт хангалтгүй бол аль ч нам, эвслийн үед төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид урвуулан ашиглах байдал давтагдах бололцоотой юм.

Мониторингийн үр дүн, дүгнэлт дээр үндэслэн дараахь ерөнхий зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

- ☞ Сонгуулийн кампанит ажлын санхүүжилттэй холбоотой хуулийн заалтыг тодорхой болгох, төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд ашиглах бүх суваг, боломжийг хаах, хариуцлагын тогтолцоог сайжруулах, хэрэгжилтийг хангах,
- ☞ Хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрийн мэдлээс гаргах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизмыг бий болгох,
- ☞ Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тухай мэдээллийг нээлттэй болгож, нийтэд хүртээмжтэй байлгах, иргэний нийгмийн хяналтын арга, механизмыг бий болгох.

## I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Мониторингийн зорилго ба зорилтууд

Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийн үндсэн зорилго нь :

- Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг (хэвлэл мэдээлэл, байгууллагын нөөц) урвуулан ашиглаж байгааг баримтжуулах
- Сонгуулийн кампанит ажлыг улс төрийн нам тэгш, шударга явуулах боломж, нөхцөлд үнэлгээ өгөх
- Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглаж байгааг улс төрийн нам, хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс үл тэвчих, уур амьсгал бий болгоход нөлөөлөх
- Сонгуулийн талаар үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл олж авах сонгогчийн эрхийг хангах.

Мониторингийн зорилт сонгуулийн кампанит ажлын үеэр телевиз, радио, сонин хэвлэл болон сонгож авсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зохиох сонгуулийн кампанийн арга хэмжээнд мониторинг хийх замаар:

- ☞ Төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглаж буй тоо, баримт цуглуулан анализ хийж, ашигласан төрийн эх үүсвэрийн хэмжээг тооцоолон гаргах
- ☞ Улс төрийн нам, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан сонгуулийн төлбөртэй суртасилгаанд мониторинг хийх
- ☞ Дээрх дүнгүүдийг улс төрийн намуудын сонгуулийн зарцуулалтын албан ёсны тайлантай харьцуулах
- ☞ Төслийн үр дүнд сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэр ашиглахыг зогсооход чиглэсэн шинэчлэл хийх талаар санал зөвлөмж боловсруулан гаргах.

### 1.2. Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит урвуулан ашиглах

Ардчилсан нийгэмд сонгуулийн кампанит ажлын санхүүжилт ил тод байх нь нэн чухал асуудал юм. Улс төрийн намын болон сонгуулийн кампанийн санхүүжилт асар их өртөгтэй байдаг. Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт хяналтгүй байх аваас хандивлагч нь намд хандив өгөхдөө эргээд өөрт ашигтай хууль тогтоомж батлуулах, эсвэл ашигтай нөхцөл бий болгох зэргээр

давуу тал олж аван нийтийн эрх ашгийн төлөө зориулах ёстой төрийн эх үүсвэрийг цөөн хүний ашиг сонирхолд зориулдаг авилгалын эх үүсвэр болгодог. Мөн түүнчлэн улс төрийн нам, ялангуяа эрх барьж буй нам төрийн эх үүсвэр, өмчийг улс төрийн зорилго буюу өөрийн сонгуулийн кампанит ажилд ашиглах явдал түгээмэл байна.

Сонгуулийн кампанит ажил авилгалтай дараахь гурван хэлбэрээр холбогддог. Үүнд:

- Улс төрийн нам болон нэр дэвшигчдэд хандив өгөөд, эргээд хууль бусаар давуу тал олж авах
- Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид урвуулан ашиглах
- Сонгогчдын саналыг худалдан авах.

Хуучин социалист системийн гэгдэж байсан орнуудад төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглаж буй нь тулгамдаж буй шийдвэрлэх ёстой асуудлын нэг юм. Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг ашиглах нь тэгш, шударга, тэнцвэртэй өрсөлдөх боломжийг хааж, төрийн эрх барьж буй улс төрийн хүчинд илт давуу байдал бий болгож, бусад өрсөлдөж буй намууд төрийн эрх мэдэлтэй “тулалдахад” хүргэдэг. Энэ тэгш бус нөхцөл нь засгийн эрх цаг ямагт аль нэг улс төрийн нам, хэсэг бүлэг хүнд хадгалагдах боломж олгон бусад улс төрийн хүчиний “өрсөлдөх” оролдлого чармайлтыг нухчин дардаг байна.

Сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг янз бүрийн арга хэлбэрээр ашигладаг ба тухайлбал “албадлагын” хэлбэрээр сөрөг нэр дэвшигчийн эсрэг үйл ажиллагаа явуулах, эсвэл “зөвлөн” хэлбэр болох сонгуулийн үед тойргийн хил хязгаарыг тогтоох, сонгуулийн хууль тогтоомжийг өөрчлөхдөө өөрт ашигтайгаар өөрчлөх, сонгуулийн дүнг өөрийн хүсэл сонирхолд нийцүүлэн тодорхойлох зэргээр илэрдэг.

Бусад улс орны туршлагаас харахад төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд зүй бусаар ашиглах байдлыг дараахь З хэлбэрт хуваадаг.

### **1. Байгууллагын эх үүсвэр ашиглах.** Жишээлбэл:

- Төрийн албан хаагч сонгуулийн кампанит ажилд оролцох, ажлын цагаа зориулах,
- Улсын машин техникийг сонгуулийн кампанит ажилд үнэгүй, эсвэл хөнгөлөлттэй үнээр ашиглах,
- Төрийн мэдлийн байр, дэд бүтцийн техник хангамжийг ашиглах,

- Сонгуулийн зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг эрх баригч намын төлөөлөл, нэр дэвшигчийн шууд харьяанд ажилладаг албан хаагчаас бүрдүүлэх гэх мэт.

## **2. Төсвийн эх үүсвэр ашиглах.** Жишээлбэл:

- Төсвийн мөнгөөр сонгогчид эд зүйлс, бэлэг тараах үйлчилгээ үзүүлэх,
- Төсвийн мөнгө амлах, эсвэл төлөвлөөгүй зүйлд үндэслэлгүйгээр, сонгуулийн кампанит ажилд зориулан хөрөнгө гаргах гэх мэт.

## **3. Төрийн мэдлийн хэвлэл мэдээлэл ашиглах.** Жишээлбэл:

- Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн нам болон нэр дэвшигчийн далд сурталчилгаа явуулах
- Төлбөртэй болон төлбөргүй нэвтрүүлгийн цагийг тэгш бусаар хуваарилах гэх мэт.

Хуучин социалист системийн гэгдэж байсан ихэнх оронд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид урвуугаар ашиглах явдал улс төрийн тогтолцоон дахь эмзэг асуудлын тоонд зүй ёсоор орох боллоо. Эдгээр оронд засгийн эрх нэг хүчний гарт байж, сонгууль хэлбэрийн төдий болон, төрийн эх үүсвэрийг өөрийн нам, хүчний санхүүжилт болгон ашигласаар ирсэн нь ажиглагддаг.

## **1.3. Төслийн зохион байгуулалт**

Төслийн удирдагчаар Сонгогчийн Боловсрол Төвийн захирал, Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүн Р.Бурмаа, төслийн зохицуулагчаар Сонгогчдын Боловсрол Төвийн ажилтан Ж.Чанцалдулам, Глоб Интернэшнл ТББ-ын ажилтан Ж.Туул нар ажиллалаа. Төслийн дүн шинжилгээний багийн гишүүнээр Д.Ламжав, Д.Цэрэнжав, С.Оюунтуяа нар ажилласан болно.

Энэхүү төслийн олон улсын хамтрагч нь Будапештэд төвтэй Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Эрх зүйн санаачлага<sup>1</sup> бөгөөд уг байгууллагын зөвлөх Др.Куентин Рид төслийн хугацаанд хамтран ажиллаж энэхүү тайланг хамтран боловсруулсан. Мөн түүнчлэн, Латвийн Провидус байгууллагын ажилтан Лолита Цигане мониторингийн аргачлал боловсруулахад туслалцаа үзүүлсэн.

Энэхүү төслийг хэрэгжүүлж эхлүүлэхийн өмнө төслийн баг Унгарын Будапешт хотноо “Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг хянах нь” бүсийн

сургалтанд хамрагдсанаас гадна олон улсын байгууллагаас зөвлөх урьж ажиллуулснаар уг төслийн аргачлалыг олон улсын стандарт болон туршлага дээр үндэслэн боловсруулсан юм.

Төслийн баг нийт 50 гаруй гишүүнтэй бөгөөд дараах гурван үндсэн хэсэгтэй ажиллалаа.

- Сонгуулийн арга хэмжээнд байгууллагын эх үүсвэр ашигласан байдалд мониторинг хийх баг
- Хэвлэл мэдээллийн мониторингийн баг
- Анализ дүн шинжилгээний баг.

Төслийн хүрээнд мониторингийн багийн гишүүдийг сургалт зохион байгуулж бэлтгэсэн ба сургалтанд Латви улсаас сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийн төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай зөвлөхийг урьж оролцуулснаас гадна мониторинг хийх аргачлалын гарын авлагыг багийн гишүүдэд зориулан бэлтгэсэн юм.

Төслийн багийн гишүүнийг сонгож авахдаа иргэний хяналт гэдэг үүднээс жирийн сонгогч дундаас сонгосон. Дүгнэлт шинжилгээний баг сэтгүүлч, хуульч зэрэг мэргэжлийн шинжээчээс бүрдсэн.

## II. МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мониторингийн аргачлалыг олон улсын байгууллагын зөвлөмж, бусад орны туршлага болон төслийн бүх гишүүний оролцоотойгоор боловсруулж бэлтгэсэн болно. Мониторингийн аргачлал нь дараах үзүүлэлтийг хамарсан.

### 2.1. Сонгуулийн арга хэмжээний мониторинг

Байгууллагын нөөцийн бусад хэлбэрээс олон нийтэд ил байдаг, мөн манай орны хувьд сонгуулийн кампанид хамгийн их ашиглагддаг нь төрийн өмчлөлийн зүйлс болох төрийн өмчийн байр, унаа, албан хаагч байдаг. Иймээс мониторингийн энэ хэсэгт сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд уулзалт, урлагийн тогтолт, сургалт семинар, сурталчилгааны материал тараахыг хамруулан авч үзэн, эдгээрт төрийн өмчийн байр, төрийн унаа, төрийн албан хаагчийг ашиглаж буй эсэхэд мониторинг хийв.

- 1. Төрийн өмчийн машин техникийн ашиглалт;** (суудлын тэрэг, нисдэг тэрэг, автобус); Нам эвсэл, нэр дэвшигчийн зүгээс сонгуулийн кампанидаа ашигласан төрийн мэдлийн машин техник хамаарсан бөгөөд төрийн мэдлийн унааг нэр дэвшигч сонгуулийн кампанидаа хэрэглэсэн эсэхэд мониторинг хийсэн.
- 2. Төрийн албан хаагчийг ашиглах;** Төрийн албан хаагчийг сонгуулийн кампанид ашиглаж буй эсэхийг дараахь үзүүлэлтээр тогтоолоо.
  - Ажлын цагаар нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны кампанит ажилд дайчлагдан ажиллах,
  - Сонгуулийн сурталчилгааны кампанит ажлын үеэр нэр дэвшигч, нам эвслийг дэмжих үг хэлэх,
  - Сонгогчийг тодорхой нам, нэр дэвшигчийн төлөө болон эсрэг саналаа өгөхийг уриалах,
  - Уулзалт арга хэмжээнд нэр дэвшигчийг дагалдан явж тэдний өмнөөс асуултанд хариулах,
  - Тодорхой нам, нэр дэвшигчийн сонгогчтой уулзах уулзалтыг албан тушаалын байдалаа ашиглан зохион байгуулах.
- 3. Төрийн мэдлийн байр ашигласан байдал:** Сонгуулийн кампанийн сонгож авсан арга хэмжээнд төрийн өмчийн байрыг үнэ төлбөргүй ашигласан байдалд мониторинг хийхдээ дараахь зүйлийг хамруулав. Үүнд: төрийн мэдлийн барилга, байшин тухайлбал, цэцэрлэг,

сургууль, соёлын төв, спорт заал зэрэг олон нийтийн үйлчилгээний газрыг арга хэмжээнд үнэ төлбөргүй ашиглаж буй эсэх.

Сонгуулийн арга хэмжээний мониторингийг 2004 оны 4-р сарын 26-наас 6-р сарын 27-ны өдрийг дуустал нийт 63 хоног буюу есөн долоо хоногийн турш хийлээ. Мониторингийг хот хөдөөгийн 13 хэсэгт /аймаг, дүүрэг гэх мэт/ явуулсан бөгөөд сонгуулийн тойргийн зохион байгуулалтаас илүүтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зохион байгуулалтыг харгалзан мониторинг хийх орон нутгийг сонгож авав. Мониторингийг 10 аймаг, 3 дүүрэг нийт 13 засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамрууллаа. Аймаг нь Хэнтий, Хөвсгөл, Омнөговь, Дундговь, Өвөрхангай, Дорнод, Архангай, Ховд, Говь-Алтай, Дархан, харин дүүрэг нь Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар.

Цаг хугацаа, орон зай, төслийн багийн гишүүний тоог харгалзан мониторинг хийсэн тухайн аймгийн төв, дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулаж буй сонгуулийн томоохон, олон нийтийг хамарсан арга хэмжээг ажиглав. Үүнд, сонгуулийн кампанийн нээлт хаалтын арга хэмжээ, сонгогчтой хийсэн уулзалт, нийтийг хамарсан урлагийн тоглолт, шоу зэргийг хамруулав.

Манай улсын хувьд сонгуулийн кампанит ажлын бусад төрлөөс голчилдог дараах сонгуулийн кампанит ажлын арга хэмжээг хамруулав. Үүнд:

- Уулзалт
- Урлагийн тоглолт
- Сурталчилгааны материал тараах
- Сургалт семинар

Сонгож авсан засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид, сонгож авсан сонгуулийн кампанийн арга хэмжээнд байгууллагын нөөцийн ангиллаас төрийн өмчийн байр, төрийн мэдлийн унаа, төрийн албан хаагч ашиглагдаж буй эсэхэд мониторинг хийхдээ бэлтгэж боловсруулсан ажиглалтын хуудсаар бүртгэж, фото зураг, шаардлагатай тохиолдолд видео камераар бичлэг хийж баримтжуулсан. Төрийн эх үүсвэрийг ноцтойгоор, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж буй онцгой тохиолдлыг фото зургаас бусад хэлбэрээр баримтжуулав. Арга хэмжээ тус бүрийн ажиглалтыг бүртгэх хуудсан дээр тухайн мэдээллийн үнэн, бодитой болохыг гэрчлэх уг арга хэмжээнд оролцсон жирийн сонгогчоор ажиглалтын бүртгэлийн хуудсыг танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулав.

төрөл, болсон газар, он сар өдөр, үргэлжилсэн хугацаа, аль нам, эвсэл, нэр дэвшигчийнх болохыг тодорхойлсон тэмдэглэл хийнэ. Дараагийн хэсэгт төрийн байр ашигласан эсэхийг бүртгэн төлбөртэй, төлбөргүй, хувийн гэдгээр нь ялан тэмдэглэгээ хийж, төлбөрийн хэмжээ, ашигласан цагийг тодорхойлно. Гурав дахь хэсэгт төрийн албан хаагч ашигласан эсэхийг бүртгэх бөгөөд төрийн албан хаагчийн нэр, албан тушаал, зарцуулсан цагийг тэмдэглэнэ. Дөрөв дэх хэсэгт төрийн мэдлийн унааг бүртгэнэ. Төрийн унааг бүртгэхдээ машины төрөл, марк, тухайн арга хэмжээний үеэр явсан км гэсэн үзүүлэлтээр бүртгэнэ. Тав дахь нь “тайлбар тэмдэглэл” гэсэн хэсэг бөгөөд мониторингийн дүн шинжилгээ хийхэд бусад хэрэгтэй мэдээлэл цуглуулах зорилготой юм. Үүнд тухайн арга хэмжээний үеэр ажиглагдсан онцлог зүйл тухайлбал, төрөл бүрийн бэлэг сэлт тараах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламж, хандивыг амлаж буй эсэх зэрэг мэдээлэл авахаар бэлтгэсэн юм.

Мониторинг хийх төслийн багийн гишүүд мониторинг эхлэхээс өмнө сонгуулийн кампанит ажилд дайчлагдаж болзошгүй машин, техник хэрэгслийн жагсаалт, тэдгээрийн марк, дугаар, өнгө, ямар байгууллагын унаа болох зэрэг мэдээлэл бүхий жагсаалт гаргасан билээ. Төрийн өмчийн байрны хувьд тухайн сонгож авсан хэсэгт сонгогчийг олноор цуглуулах боломжтой, сонгуулийн арга хэмжээнд ашигладаг байрны болон өмчлөгчийн жагсаалтыг гаргасан. Мониторинг хийсэн ажиглагчид ажигласан арга хэмжээндээ ашигласан төрийн унааг марк тус бүрээр, явсан км-ээр нь тэмдэглэн бүртгэж авлаа.

Сонгуулийн кампанит ажлын хугацаанд мониторингийн урьдчилсан дүн мэдээг олон нийтэд тогтмол танилцуулах үүднээс орон нутгаас З хоног тутамд ажиглалтын бүртгэлийн хуудсаа төслийн төв багт татаж авч байв. Зарим нэг алс аймгийн хувьд цаг алдахгүйн үүднээс ихэнх мэдээг факсаар авч байсан бөгөөд зарим тохиолдолд утсан харилцаа ашиглаж байлаа. Ажиглалтын хуудас гол төлөв орон нутгийн шуудан, зарим тохиолдолд хүнээр дамжин ирж байв. Төслийн дүгнэлт шинжилгээний баг долоо хоног тутам тайлан, мэдээ гаргаж байсан бөгөөд ажиглалтын бүртгэлийн бүх маягт энд төвлөрч байлаа.

## 2.2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

Хэвлэл мэдээллийн мониторингийн хүрээнд төрийн өмчийн болон хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан улс төрийн намууд, нэр дэвшигчдийн сонгуулийн төлбөртэй сурталчилгаа болон далд суртачилгаа хамарсан.

## 1. Сонгуулийн төлбөртэй сурталчилгаа

Сонгуулийн төлбөртэй сурталчилгаа гэдэг нь сонгуулийн үеэр аль нэг нам буюу нэр дэвшигчийн нэр, лого, мөрийн хөтөлбөрийг олон нийтэд таниулахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн нам, нэр дэвшигчээс төлбөртэй явуулж буй сурталчилгаа, захиалгат нэвтрүүлэг юм. Зар сурталчилгааны тухай хуулийн 6-гийн 1-т зааснаар “Зар сурталчилгаа … агуулга хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна”. Сонгуулийн сурталчилгаа нь олон нийтэд тодорхой, ойлгогдохуйц байдаг.

## 2. Далд сурталчилгаа

Сонгуулийн далд сурталчилгаа гэдэг нь сонгуулийн нийтлэл, нэвтрүүлэг сурталчилгааны шинжтэй буюу улс төрийн нам, нэр дэвшигчийн талаар тэнцвэртэй бус, дагнасан мэдээлэл агуулсан, дүгнэлт өгсөн, байр суурь илэрхийлсэн боловч төлбөртэй улс төрийн сурталчилгаа гэдгээ тодорхойлоогүй, эсвэл бүрхэг тайлбарласан нийтлэл, нэвтрүүлэг юм. Үүнд улс төрийн нам, нэр дэвшигчийн оролцсон үйл явдал, асуудлыг зориуд хамаатуулах, ямар нэгэн үйл явдал, асуудлыг улс төрийн тодорхой намын албан тушаалтан, нэр дэвшигчээр зөвхөн нэг талаас тайлбарлуулах, тэдний санал бодлыг тусгайлан авч оруулах, бодитой шаардлагагүй үед улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, зураг, дүрс, нэр, тэдний дуу хөгжим зэргийг анхаарал татахуйцаар нийтлэх, үзүүлэх, сонсгох зэрэг хамаарна.

Телевиз, радио болон сониныг төрийн эрх барьж буй улс төрийн хүчин сонгуулийн далд сурталчилгаанд ашиглахдаа

- Төрийн үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг хөндлөнгийн дүн шинжилгээ, дундыг барьсан байр суурьгүйгээр зөвхөн сайшаан мэдээлэх, магтах, эсвэл аливаа шүүмжлэлийг няцаасан сөрөг сурталчилгаа явуулах замаар тэрхүү төрийн бодлогыг барьж буй эрх баригч намыг давхар сурталчлах,
- Сонгуульд нэр дэвшсэн төрийн дээд албан тушаалтан, сайд дарга нарын өдөр тутмын ажил албыг сурвалжлан мэдээлэхдээ магтах аргаар тэдний сонгуулийн сурталчилгааг давхар хийх явдал багтсан. Сонгуульд нэр дэвшсэн төрийн дээд албан тушаалтан, сайд, дарга нарын үйл ажиллагааг мэдээлэхдээ улс төрийн нам, тэдгээрийн гишүүн, нэр дэвшигч гэсэн утгаар мэдээлж, танилцуулах, илт магтах замаар нэг талыг барьсан, дагнасан нэвтрүүлэг/нийтлэл сонгуулийн сурталчилгааг давхар хийх байдаар ашигладаг байна.

Хэвлэл мэдээллийн мониторинг сонгуулийн кампанит ажлын албан ёсны хугацаанд үргэлжилсэн боловч сонгуулийн санал хураалтын дүнг гаргах үйл явц сунжирч, зарим тойрот дахин санал хураалт явсан буюу маргаан өрнөх тэр хугацаанд улс төрийн намын сурталчилгаа тасралтгүй үргэлжилсэн тул мониторингийг тодорхой хугацаанд түүвэр байдлаар үргэлжлүүлсэн болно. 2004 оны УИХ-ын сонгуульд оролцсон улс төрийн намын сонгуулийн зардлын тайланг 2004 оны 9-р сард Сонгуулийн ерөнхий хорооноос албан ёсоор зарласны дараа мониторингийн тоон үзүүлэлттэй харьцуулан эцсийн дүгнэлт хийх боломж бүрдлээ.

Мониторингийн багийн гишүүд сонгож авсан телевиз, радиогийн тогтоосон цагийн бүх нэвтрүүлгийг үзэж, мөн сонгож авсан сонины энэ хугацаанд гарсан дугаарыг бүрэн уншсан ба эдгээрээс 2004 оны УИХ-ын сонгуультай ямар нэгэн байдлаар холбоотой нийтлэл, нэвтрүүлгийг урьдчилан бэлтгэсэн шалгуурын дагуу ажиглаж бичлэг хийн бүртгэл хөтлөв. (Хүснэгтийн маягтыг хавсралтаас үзнэ үү.) Эдгээр бүх нэвтрүүлгийн бичлэг ба сонины дугаарыг архивлав.

Мониторинг хийхдээ нэвтрүүлэг, нийтлэлд зөвхөн хөндлөнгийн байр сууринаас хандах зарчмыг баримталсан бөгөөд тухайн агуулгыг дүгнэлт, зөвхөн улс төрийн аль нам хүчин, нэр дэвшигчийн төлөө ба эсрэг агуулгатай алин болох, ямар арга хэлбэрээр явуулсан зэргийг баримтжууллаа. Хэвлэл мэдээллийн мониторингт дараах телевиз, радио, сонинг хамруулав.

## Телевиз

1. Монголын Үндэсний телевиз (төрийн өмчийн харьялалтай)
2. UBS телевиз (Улаанбаатар хотын харьялалтай)
3. "25-р суваг" телевиз (хувийн өмчийн харьялалтай)
4. TV5 телевиз (хувийн өмчийн харьялалтай)
5. TV9 телевиз (хувийн өмчийн харьялалтай)

Бүгд Улаанбаатар хотоос үйл ажиллагаа явуулж нэвтрүүлгээ нэг нь нийслэл хотод, нэг нь улс орон даяар, бусад нь зарим аймаг, хотод бичлэг зэрэг бусад хэлбэрээр цацдаг 5 телевиз хамрагдлаа.

## Радио

1. Монголын Үндэсний радио (төрийн өмчийн харьялалтай)
2. "Улаанбаатар" радио (Улаанбаатар хотын харьялалтай)

Монголын Үндэсний радио үндэсний хэмжээнд нэвтрүүлэг цацдаг, "Улаанбаатар" радио Улаанбаатар хотын ИТХ-ын харьялалтай, нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэг цацдаг.

### Өдөр тутмын сонин

1. “Өдрийн сонин” (хувийн өмчийн харьялалтай)
2. “Зууны мэдээ” (хувийн өмчийн харьялалтай)
3. “Өнөөдөр” (хувийн өмчийн харьялалтай)
4. “Үнэн” (МАХН-ын харьялалтай)
5. “Монголын мэдээ” (хувийн өмчийн харьялалтай)
6. “Улаанбаатар таймс” (Улаанбаатар хотын харьялалтай)

Монголд гарч байгаа өдөр тутмын зургаан сонинг бүрэн хамруулав. “Үнэн” сонинг хамруулсан нь уг сонин бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг ба бусад сонины адил төлбөртэй сурталчилгаа нийтэлж реклам сурталчилгааны зах зээлийн тодорхой хувийг эзэлдэгтэй холбоотой юм.

### Долоо, арав хоног тутмын сонин

1. “Сэргүүлэг” (хувийн өмчийн харьялалтай)
2. “Хүмүүс” (хувийн өмчийн харьялалтай)
3. “Зиндаа” (хувийн өмчийн харьялалтай)
4. “Монголчуудын амьдрал” (хувийн өмчийн харьялалтай)

Шар сониноос 2004 оны 2-р улирлын байдлаар хамгийн олон уншигчтай эдгээр сонинуудыг сонгон авч мониторингт хамрууллаа.

Мониторингт хамрагдсан MYTB, UBS, “25-р суваг”, TV5, TV9 телевизийн нэвтрүүлгийн бичлэгийг нэг газарт төвлөрүүлж хийсэн болно.

Телевизийн мониторингийг ажлын өдөрт 18-24 цаг, амралтын өдөр 09-13, 18-24 цагт мониторинг хийсэн боловч сонгуулийн арга хэмжээ олширсон, зарим телевиз сонгуулийн сурталчилгааг 24 цагаас хойш явуулж байсан тул болж мониторингийн цагийг сунгав. Түүнчлэн мониторингт зарим телевиз урьд оройн хөтөлбөрөө ажлын өдрийн өглөө давтан, нэр дэвшигчийн ярилцлагыг нэвтрүүлж, харин үдээс хойш шуурхай мэдээллийн хөтөлбөр нэмж оруулж байсан нь хамрагдсан.

Сонини нийтлэлийг нэг бүрчлэн уншиж сонгуультай холбоотой бүх нийтлэлд бүртгэл хөтлөв. Зарим сонин тодорхой нам, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны тусгай дугаар, хавсралт зэргийг бэлтгэн хэвлүүлж, нийтэд биш, зөвхөн тухайн нутаг орон, сонгуулийн тойрогт тараасан тул мониторингт хамрагдаагүй.

Мониторингт хэрэглэсэн нэвтрүүлэг хэмээх ойлголт тухайн телевиз, радиогоор эфирт цацсан бүх дурс, дууг (телевиз, радиогийн сэтгүүл зүйн төрлүүд төдийгүй зар, реклам сурталчилгаа, дуу хөгжим г.м.) хамарсан. Сонины нийтлэл тухайн сонинд нийтэлсэн бүх текст, зураг дүрсийг (сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зар, реклам сурталчилгаа, гэрэл зураг, гар зураг, шог зураг, фото зураг, чимэглэл г.м.) хамарсан. Харин сонинд хавсаргасан, наасан, хавчуулсан нэмэлт материал, дурсгалын ном зэргийг хамраагүй болно.

## 2.3. Төрийн эх үүсвэр ашигласан санхүүгийн зардлыг тооцсон аргачлал

### 1. Сонгуулийн арга хэмжээний мониторинг

#### 1. Байгууллагын нөөц урвуулан ашигласан нэг удаагийн тохиолдлын санхүүгийн зардлын тооцоо

- Төрийн унаа ашигласан өртөг тооцох

Унааны өртөг тооцохдоо шатахууны зардлаас гадна тухайн техникийн ашиглалтын зардал, элэгдэл хорогдол, жолоочийн зардал зэргийг тооцов. Унаа ашигласан зардлыг тооцохдоо унаа түрээсэлдэг хэд хэдэн байгууллагын Үнийн саналыг судалж үзсэн ба Засгийн газрын автобааз, тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Ви Жи Трейдинг”, “Жуулчин” компанийн үнийн тариф дээр үндэслэв. Унааны зардал тооцоход ашигласан үнийг тооцож гаргахдаа түрээсийн төлбөрийн хамгийн доод, дундаж, дээд үнэ гэсэн гурван үнийн дүнг дундажлан гаргалаа. Унааны зардал тооцохдоо сонгуулийн кампанит ажилд ашигласан автомашины зардлыг оруулан тооцсон бөгөөд нисдэг тэрэг ашигласан тохиолдлыг оруулсангүй.

Төрийн унаа ашигласан өртөг тооцоход сонгуулийн кампанийн ижил арга хэмжээнд ашигласан автомашиныг доорхи тарифаар тооцсон бөгөөд хамгийн бага үнэ, дундаж үнэ, хамгийн их үнийг дундажлан, дундажийг өртөг тооцоход ашиглав.

Хүснэгт 1. 1 км-т зарцуулах бензиний үнэ, төгрөгөөр

Тооцож болох хамгийн бага үнэ	Тооцож болох дундаж үнэ	Тооцож болох хамгийн их үнэ	Дундаж үнэ
280	350	600	410

- *Төрийн өмчийн байр ашигласан өртөг тооцох*

Төрийн өмчийн байр ашигласан өртгийг тооцоходоо зөвхөн төрийн өмчийн байранд төлбөр төлөхгүйгээр зохиосон арга хэмжээг хамааруулан авч үзэв. Сонгуулийн кампанийн арга хэмжээг зохион байгуулахад төрийн өмчийн байранд хэдий хэрийн төлбөр төлж байсныг нэр дэвшигч, сонгуулийн штаб, тэнд ажиллаж байсан хүмүүстэй ярилцлага хийж, мэдээлэл авах замаар тодруулав. Хөдөө орон нутаг, нийслэлийн хэмжээнд сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ зохион байгуулж байсан байрны түрээсийн үнэ харилцан адилгүй боловч доод, дунд, дээд үнийг харьцуулан дундаж үнийг тооцлоо. Тооцож болох хамгийн бага үнээр орон нутагт сургуулийн заал, танхим, гадаа талбай түрээсэлдэг үнийг сонгож авсан бол, дундаж үнээр орон нутагт хамгийн их хүн цуглардаг соёлын төв, клубийн түрээсийн төлбөрийг, харин хамгийн их үнээр нийслэл, төв суурин газрын соёлын төв, чуулгын байр зэрэг олон хүн цуглах боломжтой байрны түрээсийг сонгон авч дундажлав. Энэхүү дундаж түрээсийн үнийг нийт ашигласан цагт нь харьцуулж өртгийг тооцсон болно.

Төрийн өмчийн байр ашигласан өртгийг тооцоход сонгуулийн кампанийн ижил арга хэмжээний түрээсийн дундаж үнийг тооцон, ашигласан цагт харьцуулж гаргасан болно.

**Хүснэгт 2. Байрыг 1 цаг ашигласны үнэ, төгрөгөөр**

Тооцож болох хамгийн бага үнэ	Тооцож болох дундаж үнэ	Тооцож болох хамгийн их үнэ	Дундаж үнэ
5000	15000	150,000	56670

- *Төрийн албан хаагч ашигласан өртөг тооцох*

Төрийн албан хаагчийг сонгуулийн кампанид ашигласан өртгийг тооцоходоо төрийн албан хаагчийн цалингийн сүлжээн дээр үндэслэн нэг цагийг 1000 төгрөгөөр (ойролцоогоор 0.8 цент) тооцсон. Хэлтэс албаны дарга нарын авч буй үндсэн болон нэмэгдэл цалинг оролцуулсан жишиг дунджаар 160000-170000 төгрөг бөгөөд нэг цагийн ажлын хөлсийг тооцоходоо ажлын 40 цагт хуваан 1 цагийн үнэ 1000 төгрөгийг гаргасан.

Нийт 1788 төрийн албан хаагч сонгуулийн кампанит ажилд ажилласан гэсэн тооцоо гаргасан бөгөөд сайд, дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга зэрэг төрийн дээд албан тушаалтан болон аймаг, сумын засаг дарга, ИТХ-ын дарга, төрийн үйлчилгээний албан хаагч багтаж байна. Албан тушаалын үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн жишгээс нь хамааран хэлтэс, албаны дарга, түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн дунджаар тооцов.

- Байгууллагын нөөц урвуулан ашигласан нийт санхүүгийн зардлын тооцоо

Мониторингт хамрагдсан 556 арга хэмжээний дундаж өртгийг нам, эвсэл бүрээр тооцон, нэг удаагийн арга хэмжээнд зарцуулагдах дундаж өртгийг тооцон гаргав. Мониторингийн багийн гишүүдийн ажиглалтын бүртгэлийн тоон дүн болон нам, эвслийн сонгуулийн штабт ажилласан хүмүүстэй ярилцлага хийсний үндсэн дээр кампанит ажлын хугацаанд нэг тойротг тухайн нэр дэвшигчээс зохиосон нийт арга хэмжээний дүнг дундажлан тооцож үзэхэд 80-90 удаагийн арга хэмжээ боллоо. Доорхи санхүүгийн тооцоог гаргахдаа доод буюу 80 удаагийн арга хэмжээ байхаар тооцов. Нэг удаагийн арга хэмжээнд байгууллагын нөөц хэдий хэр ашиглагдсанаас хамааран тойргийн төвшинд тооцоо хийж, түүнийгээ үндэсний төвшинд тооцсон болно.

Дэлгэрэнгүй санхүүгийн тооцоог тайлангийн 5.4 хэсгээс үзнэ үү.

## 2. Хэвлэл мэдээллийн мониторинг

Мониторингт хамрагдсан хэвлэл мэдээллийн бүх байгууллагаас 2004 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг, нийтлэлийн төлбөрийн албан ёсны тарифийг авсан ба түүн дээр үндэслэн сурталчилгааны үнийн дүнг тооцоолон гаргав.

Сонгуулийн сурталчилгааны хэмжээг (ургэлжилсэн хугацаа) тогтоох, ялангуяа мөнгөн дүнг илэрхийлэхэд тулгарсан асуудал телевиз, радиогийн нэвтрүүлгийн давталт байсан юм. Мониторингт хамрагдсан бүх телевизийн оройн нэвтрүүлэг маргааш өглөө, радиогийн өглөөний нэвтрүүлэг үдээс хойш, заримдаа өөр өдөр давтдаг. Энэ нь сонгуулийн агуулгатай ихэнх нэвтрүүлэгт мөн адил хамаарч байлаа. Давталт үнэгүй боловч зарим нэр дэвшигчийн ярилцлагыг давтсан боловч заримыг давтахгүй. Энэ нь тухайн телевизийн байр суурьтай холбоотой байв.

Сонгуулийн төлбөртэй болон далд сурталчилгааны санхүүгийн тооцоог гаргахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн зар сурталчилгааны дундаж тарифыг нам тус бүрийн нэвтрүүлж, нийтэлсэн төлбөртэй болон далд сурталчилгааны нийт минут болон сонины хэмжээгээр үржүүлэн гаргасан. Энэхүү хэвлэл мэдээллийн тариф үнэ нь 2004 оны УИХ-ын сонгуулиар мөрдөгдөж байсан үнийн тариф ба мониторингт хамрагдсан бүх хэвлэл мэдээллээс авсан болно. Мониторинг далд сурталчилгааг үнэлэхдээ төлбөртэй сурталчилгааны тарифын нэгэн адил үнэлсэн болно. Далд сурталчилгаа нь улс төрийн намуудаас санхүүжүүлсэн байх албагүй бөгөөд энэ тохиолдолд

хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэвтрүүлж, нийтлэснээрээ санхүүжүүлэгч нь болж байдаг.

**Хүснэгт 3. Санхүүгийн тооцоонд ашигласан хэвлэл мэдээллийн сурталчилгааны тарифууд (төгрөгөөр)**

*Телевизийн сурталчилгааны тариф*

Телевиз	MUTV	UBS	TV5	TV25	TV9
Нэгжийн үнэ	174,000	110,000	95,000	60,000	131,000

*Радиогийн сурталчилгааны тариф*

Радио	Монголын Үндэсний Радио	Улаанбаатар Радио
Нэгжийн үнэ	50,000	7,000

*Сонини сурталчилгааны тариф (төгрөгөөр)*

Сонин	Үнэн	Зүүнэ мэдээ	Өдрийн сонин	Өнөөдөр	Монголын мэдээ	Хүмүүс	Монголчуудын амьдрал	Сэргүүлэг	Зиндээ
Нэгжийн үнэ	10,800	16,200	16,200	20,500	13,500	35,100	20,500	32,400	21,600

## III. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 3.1. Хуулийн заалтууд

Монгол улс 1992 онд шинэ Үндсэн Хуултай болсон бөгөөд тус хуульд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж тодорхойлсон байдаг. Үндсэн Хуулийн тэгш, шударга байх эдгээр зарчмыг бусад хууль тогтоомжийн тулгуур зарчим болгон өөрчлөх, хуулиа шинэчлэн боловсруулах, батлах үйл явц тэр үеэс эхэлсэн.

Улс төрд оролцож буй субъект тэгш эрхтэй байх, сонгуульд өрсөлдөх нөхцөл боломж адил тэгш байх, төрийн өмчлөлийн аливаа зүйл ард түмний нийтийн өмч зэрэг үүднээс энэ асуудлыг зохицуулж буй аливаа хууль тогтоомж, дүрэм журмыг нэлээд өргөн хүрээнд авч үзэв.

Хэдийгээр сонгуулийн кампанийн санхүүжилтийн тухай тусдаа хууль байхгүй, төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанийн санхүүжилтэнд ашиглахыг нэр заан, шууд хориглосон заалт сонгуулийн хууль тогтоомжид байхгүй ч, “албаны бус зорилгод” төрийн эх үүсвэрийг ашиглах, тухайлбал, төрийн албан хаагч, төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэрийг ашиглахгүй байх тухай зарим заалтууд Аivilgalын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуульд байна. Түүнчлэн мониторингийг хийхдээ Монгол улсын үндсэн хууль, Монгол улсаас нэгдэн орсон гэрээ конвенц, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хуулийн дараах холбогдох зүйл заалтыг үндэс болгов.

- Сонгуулийн кампанит ажил зохион байгуулах адил тэгш боломжтой холбоотой хуулийн заалтууд.

#### УИХ-ын сонгуулийн тухай хууль:

Тавдугаар бүлэг. Нам сонгуульд оролцох, сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа.

21 дүгээр зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа Сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо чөлөөтэй тайлбарлан таниулах, нэр дэвшигчээ сурталчлах зорилгоор хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулах, ухуулах байр ажиллуулах эрхтэй.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн өмнөх сурталчилгааны зориулалттай уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг аймагт сумын Засаг дарга, нийслэлд дүүргийн Засаг даргаас зөвшөөрсөн гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулна.

30 дугаар зүйл.

Нэр дэвшигчийг тойротоо ажиллахад ажлын газар, байгууллагын захиргаа хууль тогтоомжид заасны дагуу ажлаас нь чөлөө олгож, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

31 дүгээр зүйлийн 2.

Нэр дэвшигчийг сонгогчтой уулзахад тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

## 2. Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн зохицуулалттай хуулийн заалтууд

### **УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ:**

Тавдугаар бүлэг. Нам сонгуульд оролцох, сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа.

21 дүгээр зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа  
Монгол Улсын радио, телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн ухуулга, сурталчилгаа, үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрот өрсөлдөгч бие даасан нэр дэвшигчид адил байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоож олгосон хугацаанаас бусад цагт нам, эвсэл, нэр дэвшигч улсын радио, телевизээр сурталчилгаа явуулбал үнэ хөлсийг төлнө.

Улс төрийн намын харьялалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно.

### **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ:**

З дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох.

.....Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.

4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох

Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

***Зар сурталчилгааны тухай хууль:***

6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага.

6.1. Зар сурталчилгаа үнэн, хэрэглэгчид хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна.

7 дугаар зүйл. Хууль бус зар сурталчилгаа

7.1. Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.

7.5. Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.

***Харилцаа холбооны хууль:***

9-р зүйлийн .1.2-т Зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн лиценц олгохоорос гадна түтгэлзүүлэх, буцааж авах эрхтэй.

***Радио долгионы тухай хууль:***

4 дүгээр зүйл. Радио долгионы өмчлөл

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэхь үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион Монгол Улсын төрийн өмч мөн.

**3. Төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглах талаарх бусад зохицуулалтуудтай холбоотой хуулийн заалтууд.**

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа.

4. "... түүнчлэн төсөвт ба төрийн өмч оролцсон байгууллага /төрийн өмчийн хэсгээс нь/-аас сонгууль зарласнаас эхлээд дуусталх/ хугацаанд хандив авч үл болно"

***Авиалгалын тухай хуулийн 7 дугаар зүйл***

...албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээлэл ашиглан завших, албан тушаалаа ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо, давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийхийг хориглоно.

***Төрийн албаны тухай хуулийн 15.1.1 зүйл***

"төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлд" төрийн жинхэнэ албан хаагч ...албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн

болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох, ...албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завшихыг хоригложээ.

#### 4. Сонгуулийн санхүүжилтийн тухай зохицуулалтууд

СЕХ-ноос 2004 онд баталсан зөвхөн зардлын сантай холбоотой “УИХ-ын сонгуулийн зардлын сан бий болгох, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” батлагдан мөрдөгдөж байна.

2002 оны 7 сарын 4-нд УИХ-аас баталсан *Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрт*:

- Авилгалтай холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аливаа сонгуульд нэр дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохыг хориглох,
- Сонгуульд оролцох улс төрийн нам сонгуулийн зардал, хандивын талаар сонгууль болохоос өмнө СЕХ-нд танилцуулж, нийтэд мэдээлдэг журам тогтоох,
- Иргэн хуулийн этгээдээс сонгуулийн сурталчилгаанд өгч байгаа хандивийн хэмжээнд хязгаар тогтоох, ... заалт оржээ.

2003 оны 10 сарын 24-нд УИХ-аас баталсан *Хүний Эрхийг хангах Үндэсний Хөтөлбөрт* нэр дэвшигч ба сонгогдсон гишүүний үйл ажиллагаа, түүний дотор тэдний сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, хандивын талаар аливаа мэдээлэл авах эрхийг сонгогчид олгоно гэжээ.

### 3.2. Хууль тогтоомжийн зөрчилд хүлээлгэх хариуцлага

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг УИХ-ын Сонгуулийн 6-р зүйлд заасан байдаг. Үүнд:

- Сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх, сонгуулийн хорооны гишүүнээс үүргээ гүйцэтгэхэд санаатайгаар саад хийх, сонгуульд оролцохоос татгалзахыг нийтэд уриалах, сүсэг бишрэлийг далимдуулах, бусдын нэрийн өмнөөс сонгуульд оролцох, санал худалдаж авах, бусад хэлбэрээр эд хөрөнгөөр татах, санал тоолох ажлыг зориуд saatuulsan зэргээр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн бол гэм буруутай этгээдийг шүүхээс 50000 хүртэл төгрөгөөр торгоно.

- Сонгуулийн хуульд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг сахилгын хариуцлага хүлээлгэхээргүй байвал шүүх 50000 хүртэл төгрөгөөр торгоно.
- Тойргийн сонгогчийг татах зорилгоор тэдэнд төлбөртэй болон төлбөргүй бараа тарааж, ахуйн үйлчилгээ үзүүлсэн нам эвсэл, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр, иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр торгоно.
- Сонгуулийн хуулиар тогтоож өгсөн журмыг хэвлэл мэдээллийн байгууллага зөрчвөл шүүх тус хэвлэл мэдээллийн байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгоно.
- Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг шүүх 250000 хүртэл төгрөгөөр торгоно.

Төрийн албаны тухай хуулийн заалтыг зөрчсөн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашигласан бол шүүх 20000-60000 хүртэл төгрөгөөр торгоно. Төрийн жинхэнэ албан хаагч:

- албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох
- албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших зэргээр Төрийн албаны хууль зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан сахилгын шийтгэл ногдуулна.

Төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулах ба дараах төрөл байна.

- сануулах
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Авилгалын хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хэргийн бүрэлдэхүүнтэй бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Авилгалын хуульд төрийн албан хаагч хувийн ашиг хонжоо олох зорилгоор:

- албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших
- албан ажлын байдлаа ашиглан зээлээр үнэт цаас, эд хөрөнгө олж авах давуу эрх эдлэх, энэ талаар бусдад давуу байдал олгох, бусдын эрхийг хязгаарлах, төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- албан тушаалынхаа эрх мэдэл, түүнд үндэслэн бусадтай тогтоосон ажил төрлийн холбоо, харилцааг ашиглан өөрийн албан үүргийн хүрээнд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд шахалт үзүүлэх
- албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо, давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийсэн бол хуульд заасны дагуу ажлаас халах, огцруулах арга хэмжээ авдаг байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 21 дүгээр зүйлийн 5-д Улс төрийн намын харьялалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглосон ба хэрэв тус хуулийг **хэвлэл мэдээллийн байгууллага зөрчвөл 250000 хүртэл төгрөгөөр торгох заалт** оржээ. Гэвч дагнасан сурталчилгааг хэн хэрхэн хянах, хариуцлага тооцох механизм алга. Сонин хэвлэлийн эздийн санал гомдлын дагуу Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт “улс төрийн намын харьялалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа” гэдгийг өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин сэтгүүлийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн ухуулга сурталчилгааны материалыг хэвлэн нийтлээгүй, нэвтрүүлээгүй атлаа бусад нам, эвсэл, нэр дэвшигчийн ухуулга сурталчилгааны материалыг хэвлэн нийтлэх нэвтрүүлэхийг хориглоно гэжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төлбөртэй сурталчилгааг бусад нийтлэлээс тодорхой заагладаг байх ёстой боловч ийм заалт хуульд байхгүй, хэвлэл мэдээлийн өөрийн зохицуулалтгүй байдлаас болж дагнасан сурталчилгааг хязгаарлах боломжгүй байdag.

### **3.3 Хууль тогтоомжийн хэрэгжилт**

Сонгуулийн хуульд зааснаар сонгуультай холбоотой аливаа хэрэг маргааныг Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн хороо хууль тогтоомжид заасан харьялал журмын дагуу хянан шийдвэрлэдэг байна. (УИХ-ын сонгуулийн хууль 43-р зүйл)

СЕХ-ны гишүүнийг УИХ-аас 5 жилийн хугацаатай томилдог. Энэ удаагийн СЕХ-ны бүрэлдэхүүн 11 гишүүнтэйгээс 9 МАХН, 1 нь нам бус, 1 нь (иргэний нийгмийг төлөөлдөг) АН-ын гишүүнчлэлтэй байсан байна. Томилогдонон дараа намын гишүүнчлэлээс түтгэлзэх хуулийн заалттай. СЕХ -ны дарга, нарийн бичгийн дарга орон тооных бөгөөд бусад гишүүн орон тооны бус байдаг. Орон тооны бус гишүүнийг дараахь албан тушаалыг харгалzan томилжээ. Үүнд:

- Цагдаагийн Ерөнхий Газрын дарга
- Улсын Дээд Шүүхийн тамгын газрын дарга
- Үндэсний Статистикийн Төв газрын дарга
- Санхүү, Эдийн Засгийн яамны төрийн нарийн бичгийн дарга
- Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд дарга
- УИХ-ын тамгын газрын нэгдүгээр орлогч дарга
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
- Нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Доод шатны сонгуулийн хороо буюу УИХ-ын сонгууль зохион байгуулах сонгуулийн тойрог хэсгийн хороо, орон нутгийн сонгууль зохион байгуулах сонгуулийн нутаг дэвсгэрийн хороог бүрдүүлэхдээ намын төлөөллийг харгалzan байгуулдаггүйгээс нэг намын төлөөлөл хэт давамгайлсан сонгуулийн хороо бий болох боломжтой.

Сонгуулийн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас наах, самбар байрлуулах талбайн зөвшөөрөл өгөх, нэр дэвшигчийг сонгогчтой уулзахад бүх талын тус дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий засаг нарны намын харьяллыг харуулбал,

- Сум, дүүргийн нийт 338 Засаг дарга нарны 306 буюу 91.3% нь МАХН, 18 буюу 5.4% нь бусад намаас байна.
- Аймаг, нийслэлийн нийт 22 засаг дарга 100 хувь МАХН-ын харьялалтай байна.

Үндсэн хуулийн заалттай холбоотой аливаа хэрэг маргаан Үндсэн Хуулийн Цэцийн харьялан шийдвэрлэх маргаанд орох тул Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16 дугаар зүйлийн 9-д заасан сонгох, сонгогдох эрхтэй холбоотой маргаан Үндсэн хуулийн шүүхийн байгууллага болох Үндсэн хуулийн цэцээр ордог. Үндсэн Хуулийн Цэц Үндсэн хуулийн заалт зөрчсөн тухай маргааныг иргэний

өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Дээд Шүүх, Улсын Ерөнхий Прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг (66-р зүйлийн 1). Үндсэн Хуулийн Цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж УИХ-д оруулах бөгөөд дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд үндсэн Хуулийн Цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. Одоог хүртэл сонгуулийн хэрэг маргааныг үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэсэн тохиолдол гараагүй байна.

2003 онд Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж 2004 оны 6 дугаар сарын 1-нээс Захиргааны хэргийн шүүх ажиллаж эхэлжээ. Захиргааны шүүхийн хэргийн харьялалд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гомдол, маргаан хамаарч байгаа бөгөөд тухайлбал, УИХ-ын 24, 59 дүгээр тойргийн сонгуулийн маргаантай асуудлыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байна.

Харин сонгуулийн хорооны хувьд доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийн талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргах журам үйлчилдэг. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий өргөдөл, гомдлыг сонгуулийн хороо хуульд заасан бүрэлдэхүүнтэйгээр буюу гуравны хоёрын ирцтэйгээр хуралдаж асуудлаа олонхийн саналаар, ажлын 10 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэдэг журамтай.

УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4,5-д “Сонгуулийн хороо сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар төр, нам, олон нийтийн зохих шатны байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд тэдгээр байгууллага, албан тушаалтан тухайн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэнэ. Сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ дотор гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрийн төр, нам, олон нийтийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй” гэж заасан байна.

Сонгуулийн кампанийн санхүүжилтийн асуудлаар СЕХ аль нэг гишүүнээрээ ахлуулсан сонгуулийн санхүүгийн хяналтын орон тооны бус албыг дэргэдээ байгуулж ажиллуулна. Уг алба улсын санхүүгийн хяналтын байгууллагын эрх эдэлж, зөвхөн сонгуулийн зардлын сангийн хөдөлгөөнд хяналт тавьж, шаардлагатай бол баримтын шалгалт хийнэ.

биелэлтийг хянан шалгах ажилд УИХ-ын гишүүнд нэр дэвшигч, түүний шадар туслах, нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, ажилтан оролцохыг хориглосон байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй гэсэн заалт, 4 дүгээр зүйлд төрийн байгууллага өөрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглосон заалт байдаг боловч Монголын үндэсний телевиз, радио нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн харьяа, Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Мөн UBS телевиз, "Улаанбаатар" радио, "Улаанбаатар таймс" сонин Нийслэлийн ИТХ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн эрх зүйн байдлын хуульд нийслэл хот өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг зөвшөөрснийг нийцүүлэн өөрчлөөгүй байгаа тул зөрчилдөж байна.

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зарим холбогдох эрх зүйн актын хүрээнд Харилцаа холбооны тухай хуульд харилцаа холбооны асуудлыг хариуцсан зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах механизм байдаггүй. Зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн лиценц олгохоос гадна түтгэлзүүлэх, буцааж авах эрхтэй, лиценз авах өргөдлийг сонгон шалгаруулахдаа шударга, тэгш байдлыг хангах, олон нийтийн эрх ашгийг эн тэргүүнд тавих шаардлага бүхий шалгуур үзүүлэлт байдаггүй. Лиценз олгох үйл явц ил тод, нээлттэй бус байдаг. Лиценз олгоходо зөвхөн техник, санхүүгийн чадавхийг харгалзах нь хангалтгүй бөгөөд аливаа хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулж буй телевиз, радиогийн байгууллагад зөрчилд нь тохирсон хариуцлага тооцох үр дүнтэй механизм бий болгох нь зүйтэй юм.

Радио долгионы хуулиар радио долгион бол төрийн өмч буюу ард түмний өмч тул хувийн радио телевиз ч мөн агаарын долгион хэмээх улс үндэстний хязгаарлагдмал нөөцийг ашигладаг, нөгөө талаар бусдын үзэл бодолд хүчтэй нөлөөлдөг хэрэгслийн хувьд сонгуулийн үед тэнцвэртэй бөгөөд ялгаваргүй ажиллах үүрэг хүлээх ёстой. Гэтэл радио долгион ашиглах лиценз авахаар өргөдөл гаргасан этгээдэд ийм үүрэг хүлээх шалгуур байхгүй байна.

## IV. УЛС ТӨРИЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 4.1. Улс төрийн орчин

Монгол Улс ойролцоогоор 2,4 сая буюу харьцангуй цөөн хүн амтай, 1 сая 565,000 ам.км, асар уудам нутаг дэвсгэртэй улс юм. Өнөөгийн нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваариар Монгол Улс 21 аймаг, 342 сум болон хотын дүүрэг, 1681 багт хуваагдаж байна. Ойролцоогоор хүн амын гуравны нэг нь нийслэл Улаанбаатар хотод байдаг ба хүн амын ихээхэн хэсэг нь хөдөө орон нутагт нүүдэлчний амьдралаар амьдарч байна. Монгол Улс доогуур орлоготой улс бөгөөд нэг хүнд ноогдох жилийн дундаж орлого 390 US\$, эдийн засгийн өсөлт харьцангуй доогуур, ажилгүйдэл ихтэй орон юм. Ядуурлын төвшин 2004 оны Үндэсний Статистикийн Газрын мэдээгээр улсын хэмжээнд 36.1 хувьтай байна.

1992 оноос хойш Монгол улсад Улсын Их Хурлын 4, Ерөнхийлөгчийн ба орон нутгийн З сонгууль болсон. Улсын Их Хурлын сонгууль 1992, 1996, 2000, 2004 онд тус тус болсон бөгөөд 1992 оны сонгуульд МАХН 76 суудлаас 71 суудал авсан бол 1996 оны сонгуульд Ардчилсан Холбоо Эвсэл 50 суудал, МАХН 25 суудал авсан юм. 2000 оны сонгуулиар МАХН 76 судлаас 72 –ыг авсан. УИХ-ын сонгууль 1992 онд олон мандаттай, улсаа 26 тойрогт хувааж, 2, 3, 4 мандаттай тойргоос сонгохоор, тэгэхдээ дунджаар 14000 сонгогчид нэг гишүүн ногдож байхаар тогтоожээ. 2, 3, 4 мандаттай тойрогт сонгогч мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн төлөө, тэгэхдээ нэг хүнд нэг л санал өгнө. Мандатын тооноос цөөн хүний нэр тэмдэглэсэн хуудсыг хүчингүйд тооцох, өөрөөр хэлбэл хоёр мандаттай тойрогт сонгогч хоёр санал буюу хоёр өөр хүнд тус бүр нэг санал, 4 мандаттай тойрогт сонгогч бүр тухайн тойргийн 4 өөр нэр дэвшигчийн төлөө дөрвөн санал өгнө. Сонгуулийн тойрогт хамгийн олон санал авсан 2, 3, 4 нэр дэвшигч ялдаг систем байсан. 1996, 2000, 2004 онд нэг мандаттай мажоритар буюу харьцангуй олонхийн саналаар суудал хуваарилах аргаар 76 тойрогт, тойрог бүр нэг мандаттай системээр сонгууль явуулсан. Нэр дэвшигч тойргийнхоо нийт сонгогчийн 25 хувиас доошгүй санал авч байж ялсанд тооцогдоно. 1992 оны УИХ-д сонгогдсон 76 гишүүн сонгогчийн нийт саналын 57.8 хувь, 1996 оны сонгуулиар сонгогдсон гишүүд нь сонгогчийн нийт саналын 53.7 хувь, 2000 оны сонгуулиар бүрдсэн УИХ нийт саналын 52.2-ийг төлөөлж байв.

Анхны орон нутгийн сонгууль 1992 онд болсон бөгөөд дараагийн ээлжит сонгууль 1996, 2000 онд тус тус болсон. Орон нутгийн сонгуулийн хуулийг 1992 онд баталсан ба 1996, 2000 онд нэмэлт өөрчлөлт хийсэн юм. Иймээс орон нутгийн З сонгууль өөр өөр сонгуулийн системээр явжээ. 1992 онд багийн

хурлаас багийг төлөөлөх сумын ИТХ-ын гишүүнийг сонгосон. 1996 онд олонхийг төлөөлөх мажоритар болон хувь тэнцүүлэх пропорциональ хоёр системийг хослуулсан хувилбараар орон нутгийн сонгууль явуулсан. 2000 оны орон нутгийн сонгууль мажоритар системээр явсан байна.

## 4.2. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын төлөв байдал

2004 оны УИХ-ын сонгуульд улс төрийн долоон нам дангаараа, гурван нам эвсэл болж оролцсон ба мөн бие даан нэр дэвшигчид оролцжээ. Энэ удаагийн сонгуулийг зохион байгуулах үүрэг хүлээсэн сонгуулийн 76 тойргийн хороо, түүний 338 салбар хороо, 1645 хэсгийн хороо ажиллаж, эдгээр хороонд 16500 орчим хүн ажиллаж, сонгуулийн 1650 хэсэгт санал авах ажил явагдсан байна.

Сонгогчийн нэрийн жагсаалтад 1331721 хүн бичигдэж, 1091203 сонгогч санал өгчээ. Нийт сонгогчийн 81,94 хувь санал өгсөн байна. УИХ-ын гишүүнээр сонгогдооор 244 хүний нэр саналын хуудаст бичигдсэний 229 нь улс төрийн нам, эвслээс, 15 нь бие даан нэр дэвшигч байв.

УИХ-ын гишүүнээр МАХН-аас 36, "Эх орон-ардчилал" эвслээс 34, БНН-аас нэг, бие даан нэр дэвшсэн гурван хүн сонгогдов.<sup>2</sup>

УИХ-д сонгогдсон гишүүний 36 нь төр захиргааны байгууллагад, 19 нь улс төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургуульд, 19 нь бизнесийн салбарт ажиллаж байсан ба тэдний 73 гишүүн дээд боловсролтой, нэг гишүүн дунд боловсролтой байна. УИХ-ын гишүүний тав нь буюу 6.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажиглалт хийсэн арван аймгийн тавд нь тухайн аймгийн засаг дарга (Дундговь, Дорнод, Өвөрхангай, Хөвсгийл, Дархан-Уул), хотын гурван дүүргийн нэгд (Сүхбаатар) тухайн дүүргийн засаг дарга МАХН-аас нэр дэвшжээ.

Үндэсний хэмжээнд явуулж буй сонгуулийн кампанит ажлын хувьд 2000 оны УИХ-ын сонгуулиас энэ удаагийн сонгуулийн кампанийн ялгарах гол онцлог шинж нь "сонгогчдын уулзалт"-аас "сонгогч нэг бүрт хандсан уулзалт", "шоу"-наас эхлээд "өрх бүрт" хандсан кампани байжээ. 2000 оны үндэсний хэмжээн

<sup>2</sup> 2004 оны 12-р сарын байдлаар УИХ-ын сонгуулийн 24, 59-р тойргийн асуудал маргаантай, шийдвэрлэгдээгүй байгаа учраас УИХ-ын 74 тойргийн байдлаархи дүн мэдээг оруулав.

дэх сонгуулийн кампани нь “шоу” арга хэмжээг дийлэнхдээ явуулан, сонгогчдын уулзалт, мөрийн хөтөлбөр бүхий сонин тараах төдийгөөр хязгаарлагддаг байсан бол 2004 онд сурталчилгаа өрх нэг бүрт хүрч, сонгогч нэг бүртэй уулзсан уулзалт, сурталчилгааны олон төрлийн самбар, өнгө үзэмж бүхий сурталчилгааны төрөл бүрийн хуудас зэрэг сонгуулийн кампанийн орчин үеийн боловсронгуй аргыг хэрэглэж байлаа. Тухайлбал, сонгуулийн сурталчилгаанд гар утасны мессежийг хүртэл ашиглаж байв.

### 4.3 Бүсад байгууллагын мониторинг

УИХ-ын сонгуулийг ОХУ, Япон, Хятад, ХБНГУ, АНУ зэрэг улс орны болон олон улсын байгууллагын 117 хүн ажиглаж, гадаад орны хэвлэл мэдээллийн агентлагийн 20 гаруй сурвалжлагч сурвалжилсан байна.

Английн Консерватив намын гишүүн ардчиллыг дэмжих Весминстерийн сангийн тусlamжтайгаар сонгуулийн үйл явцыг ирж ажигласан бөгөөд сонгуулийг ерөнхийд нь “эрх баригч МАХН эрх мэдлээ ичгүүргүйгээр хэтрүүлсэн, төрийн механизмыг буруугаар ашигласан сонгууль боллоо” гэж дүгнэсэн байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Ханс Зайделийн сангийн ажиглагч Ренате Борманн “Улаанбаатар хот болон ялангуяа хөдөө орон нутагт очсон гаднын хэний ч нүдэнд Монгол улсад МАХН гэдэг нэг л нам байдаг мэт ойлголт төрөхөөр дүр төрх харагдаж билээ. МАХН сонгуулийн сурталчилгааныхаа зурагт хуудсыг бүхий л гудамж, зам дагуу байрлуулсан төдийгүй намын сурталчилгааны хүмүүс тухайн намаас нэр дэвшигчийн тойрот байрлах байр, байшин, гэр бүрт сурталчилгааны ухуулгын сонин, гарын авлага, хуудас зэргийг тараах ажлыг цуцалтгүй хийсээр байгаа нь ажиглагдсан. Мөн улсын радио, телевизээр ч ийм дүр төрх байнга мэдрэгдэж байв” гэж тэмдэглэсэн байна.

Америкийн Нэгдсэн Улсын элчин сайдын яамны шугамаар гадаадын олон ажиглагч ирж ажилласан бөгөөд элчин сайд Памела Ж.Слуц СЕХ-нд хандан захидал илгээв. Энэ захидалд сонгуулийг зохион байгуулдаг байгууллага, мөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нар дийлэнхдээ эрх барьж буй нэг намынх байгаа, сонгуулийн санал авах үйл явцад засаг дарга нар хэт хутгалдан оролцож байгаа, цагдаа нар сонгуулийн байрны дотор болон гадаа санал авалтын туршид байнга байгаа зэрэг олон асуудлыг анхаарч үзэхийг хүссэн байна.


## V. МОНИТОРИНГИЙН ДҮН

### 5.1. Сонгуулийн арга хэмжээний мониторинг

Сонгуулийн арга хэмжээний мониторингт нийт 556 арга хэмжээ хамрагдлаа.

Ажигласан 556 удаагийн арга хэмжээ давхардсан тоогоор:

- 466 уулзалт
- 169 урлагийн тоглолт
- 20 сургалт семинар
- 89 сурталчилгааны материал тараах арга хэмжээ байна.



Нэр дэвшигчийн нэг удаагийн арга хэмжээнд уулзалт, урлагийн тоглолт, сурталчилгааны материал тараах арга хэмжээ зэргийг зохион байгуулдаг тул тоо давхардаж оров. Харин ажигласан арга хэмжээг нам эвслийн харьяллаар авч үзвэл:

- 295 нь буюу 53% нь MAXH
- 243 нь буюу 44% нь Эх орон-Ардчилал эвсэл /МАН, МАШСН, ИЗБНН/
- 11 нь буюу 2% нь БНН
- 7 нь буюу 1% нь бие даан нэр дэвшигчийн арга хэмжээ байлаа.

Улс төрийн нам эдгээр арга хэмжээндээ төрийн өмчийн байр үнэгүй ашиглаж байсныг намаар авч үзвэл 80 хувь нь MAXH, 20 хувь нь Эх орон-Ардчилал эвслийн арга хэмжээ байсан.

Энэхүү 556 арга хэмжээнд ашигласан төрийн унааны 98 хувь нь MAXH, 2 хувь нь Эх орон-Ардчилал эвслийнх байна. Харин төрийн албан хаагч ашигласан байдлын 99 хувь нь MAXH-ын арга хэмжээнд, 1 хувь нь Эх орон-Ардчилал эвслийн арга хэмжээнд хамаарч байна.

Ажигласан 556 арга хэмжээний зардлыг жишиг болгон авч, урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийг үндэсний хэмжээнд (76 тойрот) тооцоолон

мөнгөн дүнгээр илэрхийлбэл нийт **1,393,034,400 төгрөг** болж байгаа ба намаар харуулбал

- MAXN 1,239,958,240 төгрөг,
- Эх орон-Ардчилал эвсэл 153,076,160 төгрөг болж байна.

● **Төрийн өмчийн байр ашигласан байдал**

Нийт 556 арга хэмжээний 195 нь төрийн өмчийн байранд болсон ба түүнээс 146 нь MAXN-ын сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ, 49 нь Эх Орон-Ардчилал эвслийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ байв. Төрийн өмчийн байранд үнэ төлбөргүй зохион байгуулсан арга хэмжээ 606 цаг болж байгаа бөгөөд, түүнээс 507 цаг нь MAXN, 99 цаг нь Эх Орон-Ардчилал эвслийн арга хэмжээ байна.

Төрийн өмчийн байрыг сонгуулийн кампанит ажилд гол төлөв арга хэмжээ зохион байгуулах, сонгуулийн сурталчилгааны байр, сонгуулийн штаб байрлуулах зэргээр ашигласан байна.

Мониторингийн ажиглалтын хоёр суманд засаг даргын тамгын газрын байрыг сонгуулийн сурталчилгааны байр болгон ашиглаж, Монгол улсын төрийн далбааны оронд намын тугийг дээвэр дээр байрлуулсан байсан. Түүнчлэн баг, хорооны засаг даргын ажлын байрыг сонгуулийн сурталчилгааны байр, сонгуулийн штабын байр болгон ашигласан байв. Тухайлбал, Мөрөн сумын нийт 10 багийн засаг дарга нарын ажлын байрыг 18 хоногийн хугацаанд сонгуулийн сурталчилгааны төв штаб болгон ашиглаж, зарим багийн засаг дарга хариуцсан багийн иргэдэд ухуулга хийн сонгуулийн сурталчилгааны плакат, самбар байрлуулан, иргэдэд тайлбарлан таниулах зэрэг үйл ажиллагаа явуулж байжээ. Мөн аймагт нийт 10 өдөр Хүүхдийн төлөө төвийн байранд нэр дэвшигч, намын мөрийн хөтөлбөрийг хэн сайн мэдэх вэ? тэмцээн, олс таталт, сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулж байсан ба энэ байранд 46-р тойргийн хэсгийн хороо байрлаж байсан байна.


Хүүхдийн цэцэрлэгийг сонгуулийн ухуулга сурталчилгааны байр болгон ашигласан нь нэлээд орон нутагт ажиглагдсан. Нийслэлийн 98 дугаар цэцэрлэг хичээлийн жилийн хаалтын арга хэмжээний үеэр MAXN-ын туг, эмблемийг нь байгууллагынхаа үүдний хаягтай зэрэгцүүлэн байрлуулж, цэцэрлэгийн цонх, хананд нэр дэвшигчийн зураг плакат хадсан нь мониторингт бүртгэгдсэн байна. Дархан-Уул аймагт хүүхдийн цэцэрлэгт нэр дэвшигч сонгуулийн штабаа байрлуулж, ухуулга сурталчилгаа хийж байсныг баримтжуулсан.

“Эх орон-Ардчилал” эвслийн арга хэмжээнд төрийн өмчийг үнэ төлбөргүй ашигласан байдлыг харахад ихэвчлэн тухайн байгууллагын шууд харьяа дарга тухайн намын гишүүний харьяалалтай байсан.

Үүнээс дүгнэхэд хүчтэй сөрөг хүчин, иргэний нийгэм, олон нийтийн хяналт, төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах бүх сувгийг хаасан хууль эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас аль ч нам, эвслийн үед энэхүү байдал давтагдаж болзошгүй. Иймд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах нь хэн нэгний буруутай, санаатай үйлдэл гэхээс илүү улс төрийн тогтолцоонд байгаа дутагдал юм.

Орон нутагт олон сонгогч цугларах боломжтой газар гол төлөв төрийн өмчийн харьяалалтай соёлын төв, спорт заал зэрэг байсан бөгөөд нам, эвсэл, нэр дэвшигч бүрт ижил нөхцөл, тэгш боломж олдохгүй, эсвэл түрээсийн үнэ харилцан адилгүй зэрэг тэгш бус нөхцөлтэй байжээ. Тухайлбал, мониторингийн нэг аймгийн Хөгжимт жүжгийн театрт зохион байгуулагдсан намуудын сонгуулийн кампанийн арга хэмжээ нь нэг нь үнэ төлбөргүй байсан ба нөгөө нь 150000 төгрөгийн түрээстэй байсан байна.

#### *Намуудын төрийн өмчийн байр үнэгүй ашигласан байдал*



- Төрийн албан хаагчийг ашигласан байдал

Ажигласан 556 удаагийн арга хэмжээнд нийт 1788 төрийн албан хаагч сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд оролцож 7798 цаг зарцуулсан байна. 1788 албан хаагчаас 1766 нь MAXN-ын сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд, 22 нь Эх Орон Ардчилал эвслийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд төрийн албан хаагчийн хувиар оролцжээ. Үүнд төрийн албан хаагчийг жирийн сонгогчийн хувиар сонгуулийн кампанийн арга хэмжээнд оролцсоныг тооцоогүй болно. Төрийн албан хаагчийг сонгуулийн кампанид ажиллуулах нь хүний нөөцийн ашиглалтаас гадна байгууллагын нөөц болох

албан контор, утас, факс, интернэт, бусад техник хэрэгсэл ашиглаж, мөн цалин авч байгаагаараа төсвийн хөрөнгийг урвуулан ашиглаж буй хэрэг юм.

Сонгуулийн арга хэмжээнд оролцсон төрийн албан хаагчийн албан тушаалын байдлыг харуулбал давхардсан тоогоор 210 нь засаг дарга, 103 нь ИТХ-ын дарга нар, 131 нь хэлтэс, албаны дарга, 85 нь Засаг даргын тамгын газрын дарга, 74 нь эмч, эмнэлгийн ажилтан, 60 орчим нь ерөнхий сайд, яамны сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, 1125 нь төрийн бусад албан хаагч байна.

Сонгуулийн кампанид төрийн албан хаагчийг ухуулга сурталчилгаанд явуулах, нэр дэвшигч сонгогчтой хийх уулзалтандaa байнга дагуулж явах, сонгуулийн штабтаа ажиллуулах, сурталчилгааны тараах материал бэлтгүүлэх, самбар хийлгэх, тараалгах зэргээр ашиглажээ. Жишээлбэл, 54 дүгээр тойротг МАХН-аас нэр дэвшигчийн сурталчилгааны материал тараах нэг удаагийн арга хэмжээнд төрийн захиргаа удирдлагын хэлтсийн 7, санхүүгийн хэлтсийн 3, хууль зүйн хэлтсийн 3, захиргаа аж ахуйн хэлтсийн 15 ажилтан ажлын цагаар оролцсон байна. Энэ арга хэмжээнд ажилласан зарим төрийн албан хаагчтай төслийн багийн гишүүн уулзсан бөгөөд нэгэн албан хаагч “сонгуулийн ажилд нойр хоолгүй зүтгэсээр ядарч байна” гэж хэлсэн байдал.

Төрийн албан хаагч, аймгийн тамгын газрын ажилтныг хөдөө суманд албаны томилотоор сонгуулийн ухуулга сурталчилгаанд дайчлан ажиллуулж байсан байна. Жишээ нь Хэнтий аймагт албан томилотоор аймгийн тамгын газрын ажилтан, агентлагийн мэргэжилтнийг тойргийн бүх суманд ажиллуулсан байжээ. Мөн, Өмнөговь аймгийн МАХН-ын хороо сонгуулийн штаб 4 ажлын хэсэг байгуулж, ахлагчийг нь томилжээ. Үүнд:

- Аюулгүй байдал, хууль зүйн хэсэг. Ахлагч нь засаг даргын тамгын газрын дарга, төрийн захиргаа хууль зүйн хэлтсийн дарга
- Санхүү, хандив тусламжийн хэсэг. Ахлагч нь засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга
- Ухуулга сурталчилгааны хэсэг. Ахлагч нь Даланзадгад сумын засаг дарга
- Дэмжигчийн хэсэг. Энэ хэсгийн 110 ухуулагчийн 37 нь ерөнхий боловсролын сургуулийн багш, бага эмч, сувилагч, нярав зэрэг төрийн үйлчилгээний албан хаагч байжээ.

Мониторинг хийсэн нэг аймагт төрийн байгууллагын ажилтныг нэр дэвшигчээс сонгогчтой хийх уулзалтанд заавал байлаах үүргийг өгч, тэдний ажил мэргэжилтэй холбогдсон иргэний асуултанд хариулуулах, хэрэгцээтэй тоо баримтаар хангахыг шаардаж байсан тухай мониторинг хийж байсан ажиглагч мэдээлсэн байна. Мөн УИХ-ын нэгэн томоохон албан тушаалтны сонгогчтой хийх уулзалтын үеэр дүүргийн тохижилт үйлчилгээтэй холбоотой асуудлыг нэр дэвшигчийн өмнөөс дүүргийн засаг дарга хариулж байсан байна.

Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Сонгох сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” мониторингийн судалгааны тайланд “Төрийн байгууллагын ажилтан нэр дэвшигчийн сурталчилгаанд ажиллах хэлбэр янз бүр байна. Зарим нь өөрийн эрх мэдлийн хүрээнд зайлшүй үзүүлэх ёстой төрийн үйлчилгээг иргэнд хүргэхдээ дэмжиж буй нэр дэвшигчээ дээрхийг хийсэн мэтээр олон нийтэд ойлгуулан сурталчилгаандаа ашиглах тохиолдол байдаг (төсвийн мөнгөөр зам тавих, цалин тэтгэврийг олгох, олон улсын тусlamж дэмжлэгийг өөрийн биеэр сонгогчид тараах гэх мэт)... Сонгуулийн үе дэх булхайт нэг үйлдэл бол өөрийн мэдэлд ажилладаг төрийн бүхий л албан тушаалтныг нэр дэвшиж буй тойротгт ажиллуулах нэрийдлээр санал өгүүлэх явдал юм...” хэмээн бичжээ.


- Төрийн өмчийн унааг ашигласан байдал

556 удаагийн арга хэмжээнээс нийт 241 удаагийн арга хэмжээнд 1033 төрийн унаа ашигласан байна. Давхардсан тоогоор 214 нь УБЗ буюу засгийн газрын дугаартай бусад унаа орон нутгийн төрийн байгууллагын дугаартай байжээ.

Сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд төрийн унаа ашигласан байдлыг намын харьяллаар харвал 1017 нь МАХН, 16 нь Эх Орон-Ардчилал эвслийн сонгуулийн кампанийн арга хэмжээнд оролцсон байна. Эх Орон-Ардчилал эвслийн төрийн унаа ашигласан байдлыг харахад тус эвслээс нэр дэвшсэн УИХ-ын гишүүний тойротгт хамаарч байна.

Сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд ашигласан 1033 төрийн унаа ойролцоогоор 51366 км явсан байгаагаас 98 хувь нь МАХН-д хамаарч байна. Ашигласан автомашиныг маркаар нь харуулбал, 84 нь жийп, 201 нь УАЗ-469, 63 нь соната, элентра, 44 нь УАЗ-31514, 31 нь микро автобус, 24 том оврын автобус, Ми-8 нисдэг тэрэг байлаа. УБЗ дугаартай автомашин буюу Засгийн Газрын унаа, мөн нийтийн тээврийн хэрэгслийг нам сонгуулийн кампанид дайчлан ашиглах нь их байжээ. Төрийн байгууллагын унааг сонгуулийн кампанид ашиглахын нөлөө зөвхөн техникийн үзүүлэлт /элэгдэл хорогдол,

бензин шатахуун/ бус жолоочийн цалин болон цаана нь төрийн ажил зогсох зэргээр нэлээд үр дагавартай юм.



**Сонгуулийн арга хэмжээнд төрийн эх үүсвэр ашигласан бодит жишээнүүд**

Жишээ: Хөвсгөл аймгийн нэг суманд төрийн унаа ашигласан байдал.

Төрийн албан хаагчийн албан тушаал	Машины дугаар	Машины Марк	Зарцуулсан нийт км
Аймгийн засаг дарга	00-01	Land Cruiser	3500
Аймгийн ИТХ-ын дарга	00-02	Парадо	300
Аймгийн засаг даргын орлогч	00-03	УАЗ-469	2000
Аймгийн засаг даргын тамгын газрын дарга	00-04	УАЗ -469	200
Түргэн тусламжийн машин	36-43		200
Эрчим хүчний үйлдвэрийн дарга	55-55	Land Cruiser	60
Санхүү хяналтын алба	54-54	Land Cruiser	160
Цагдаагийн газрын дарга	00-99	Land Cruiser	130
Цагдаагийн газар	08-99	УАЗ -469	160
Нэгдсэн эмнэлэг	30-81	УАЗ -469	170
Нэгдсэн эмнэлгийн дарга	54-72	УАЗ -469	280
Хөдөөгийн ядуурлыг бууруулах хотолбер	99-99	Land Cruiser	100
Цагдаагийн газар	26-28	УАЗ -469	80
Цагдаагийн газар	43-96	УАЗ -469	40
Цагдаагийн газар	22-32	УАЗ -469	40
Гал түймэртэй тэмцэх газар	22-63	УАЗ -469	30
Гал түймэртэй тэмцэх газар	22-65	УАЗ -469	80
Мэргэжлийн хяналтын алба	31-15	УАЗ -469	120
Хүүхдийн төлөө төв	44-70	УАЗ -469	90
Мэргэжлийн хяналтын алба	45-76	УАЗ -469	60
Нийгмийн даатгалын хэлтэс	51-16	УАЗ -469	60
Мөрөн сумын засаг дарга	28-93	УАЗ -469	60
Татварын хэлтэс	45-61	УАЗ -469	130
Ө. Энхтувшин /УИХ-ын гишүүн/	05-81 УБ3	Land Cruiser	5100
Б. Эрдэнэбат /УИХ-ын гишүүн/	04-75 УБ3	Hammer jeep	1800
Нийт дүн			14950 км

**Жишээ: Сонгуулийн кампанит ажилд эмнэлгийн байр, түргэн тусlamжийн машин болон эмч, эмнэлгийн ажилтнууд дайчлагдсан тохиолдлууд**

- Дундговь аймгийн Говь-Угтаал сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч эмнэлгийн байрыг МАХН-ын сонгуулийн сурталчилгаанд ашиглан, намын тугийг эмнэлгийн дээвэр дээр байрлуулан, өвчтөнг сонгуулийн кампанийн хугацаанд гэрт нь гарган сурталчилгааны багийнхныг байрлуулжээ. ДУА 20-26 дугаартай түргэн тусlamжийн тусгай тоноглолтой унааг сонгуулийн сурталчилгаанд ашиглан, сонгуулийн кампанит ажлын хугацаанд намын сонгуулийн кампанийн ухуулга хийсэн байна.
- Баян-Өлгий аймгаас 210 км-т оршдог “Күй” тосгоноос амаржих дөхсөн нэгэн эмэгтэй дуудлага өгөх үед аймгийн нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч нар аймгийн нэгдсэн эмнэлгийн машинаар МАХН-аас нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд явсан байжээ. Түргэн тусlamжийнхан хөнгөн тэргээр оройн 17 цагийн үед буюу дуудлага өгснөөс хойш 7 цагийн дараа уг тосгонд очсон ба тэр эмэгтэй ихээхэн цус алдсанаас болж эмнэлгийн тусlamж авч чадалгүй нас баржээ. (Мэдээлэл “Өдрийн сонинны” 2004 оны 06 сарын 16-ны дугаарт гарсан)
- Хөвсгөл аймагт 36-43 дугаартай түргэн тусlamжийн машин нэр дэвшигчийн уулзалт, хүлээн авалтад сонгогчийг 2 өдөр зөөж байсан ба аймгийн нэгдсэн эмнэлгийн 20-иод эмч энэ уулзалтын арга хэмжээг зохион байгуулжээ.

**Жишээ: Сонгуулийн арга хэмжээ**

Сонгуулийн арга хэмжээнд төрийн эх үүсвэр буюу албан тушаалаа ашигласан жишээ болгох доорх жишээг авлаа.

Иргэнийг бичиг баримтжуулах ажил нь Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төвийс 2004 оны 05 сарын 01-нээс эхэлсэн бөгөөд иргэний үнэмлэх аваагүй болон хаяж үрэгдүүлээд торгууль төлж авч чадахгүй байгаа иргэд үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр авах боломж олгож, энэ чиглэлийн үйлчилгээг эрхэлдэг төрийн байгууллага амралтын өдрөөр болон ажлын өдөрт уртасгасан цагаар ажиллаж байв. СЕХ нь Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төвд хандан санхүүгийн асуудлыг шийдэхийг зөвлөж, сонгуулиас өмнө иргэнийг бичиг баримтжуулах ажлыг ийнхүү явуулж, холбогдох хөрөнгийг Санхүү Эдийн Засгийн яам гаргасан байна.


Нийслэл хотын Сонгинохайрхан дүүрэгт МАХН-аас УИХ-д нэр дэвшигч, Улаанбаатар хотын ерөнхий менежер Т.Бадамжунай нь өөрийн сонгуулийн арга хэмжээний хүрээнд 2004 оны 05 сарын 24-ний өдрөөс 5 хоногийн хугацаанд нийслэлийн 42 дугаар дунд сургууль дээр 67 дугаар тойргийн иргэний бичиг баримтын зөрчилтэй болон иргэний үнэмлэх аваагүй иргэнийг бичиг баримтжуулах ажил хийжээ. Энэ өдрийн UBS телевизийн оройн мэдээллийн хөтөлбөрөөр “67 дугаар тойрогт нэр дэвшигч Бадамжунайн сонгуулийн сурталчилгааны нээлтийн арга хэмжээнд нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдлага хүрэлцэн ирж оролцлоо. Хүн ам, нийгмийн шийдвэрлэх асуудал, ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөн, газрын зөрчил маргаан УИХ-ын сонгуулийн 67 дугаар тойрогт харьцангуй их. Энэ ч үүднээс тус тойрогт

нэр дэвшигч MAXH-ын үндсэн хөтөлбөр болоод өөрийн мөрийн хөтөлберийн хүрээнд тодорхой ажил хийхээр төлөвлөжээ. Сурталчилгааныхаа нээлтийн арга хэмжээний үеэр хөдөө орон нутгаас шилжин ирсэн бичиг баримтгүй иргэний бичиг баримтын зөрчлийг арилгах арга хэмжээг авахаа мэдэгдсэн юм. Өнөөдөр УИХ-ын 67 дугаар тойргийн дэмжигч 3000-аад хүн иргэний үнэмлэхээ үнэ төлбөргүй гардан авч байна” гэсэн мэдээ нэвтрүүлэв.

Нэр дэвшигч нь нэгэнт хийгдэх төрийн үйлчилгээг Улаанбаатар хотын ерөнхий менежер гэсэн албан тушаалынхаа байдлыг өөрийн сонгуулийн сурталчилгаандаа ашигласан байна.

## 5.2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

2004 оны УИХ-ын сонгуулийн кампанийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан сурталчилгааны дийлэнх нь далд сурталчилгаа байсан. Сонины нийт сурталчилгааны 96 хувь, телевизийн нийт сурталчилгааны 66 хувь, радиогийн нийт



сурталчилгааны 34,6 хувь далд сурталчилгаа байлаа. Сонгуулийн кампанийн хугацаанд сонгож авсан 5 телевиз, 2 радио, 10 сониноор явуулсан нийт 4 тэрбум 440,2 сая төгрөгөөр үнэлэгдэх сонгуулийн төлбөртэй болон далд сурталчилгаа байгаа ба үүнээс төрийн өмчийн хэвлэл мэдээллээр

2 тэрбум 2562,5 сая төгрөгтэй тэнцэх сурталчилгаа явуулсны 83,2 хувь нь MAXH, түүний нэр дэвшигчид ногдох байна. Сонгуулийн сурталчилгааны 74,4% нь далд сурталчилгаа байсан ба намаар харуулбал MAXH 88,4 хувь, “Эх орон-Ардчилал” эвсэл 7,8 хувь, бусад нам 3,0 хувь, бие даан нэр дэвшигч 0,7 хувь байна.

### 1. Сонгуулийн төлбөртэй сурталчилгаа

Телевиз, радиогийн хувьд төлбөртэй сурталчилгааны үндсэн хэлбэр сонгуульд оролцож буй улс төрийн нам, нэр дэвшигчийн сурталчилгааны телевизийн клип байлаа. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанийн нэг онцлог бол уран сайхны нэлээд дээд түвшинд хийсэн олон тооны клипийг сурталчилгаанд ашигласан явдал юм. Намын нэр, уриа, мөрийн хөтөлбөрт орсон амлалт, нэр дэвшигчийн нэр, дүр, хувийн амлалтыг сонгогчид хүргэх зорилго бүхий эдгээр клипийг зар сурталчилгааны цаг, эсвэл сонгуулийн зар сурталчилгааны

тусгай цагаар, бусад нэвтрүүлгийн дундуур явуулж байлаа. Эдгээр клип сонгуулийн төлбөртэй сурталчилгаа тул чанарын үзүүлэлт гаргахгүй, гарсан тоо, үргэлжилсэн хугацаа, нам, эсвэл, бие даасан нэр дэвшигчид хамаарахыг бүртгэсэн болно. Сурталчилгааны клипийг МАХН, "Эх орон-Ардчилал" эвсэл, тэдгээрийн нэр дэвшигч хамгийн их захиалж явуулсан байна.

Хүснэгт 4: Телевизийн төлбөртэй сурталчилгаа (минутаар)

	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Төрийн өмчийн телевиз	1879,5	828	674,8	45	3427,3	46,4
Төрийн өмчийн бус телевиз	2283,2	1467,7	172,2	34,7	3957,8	53,6
Бүгд	4162,7	2295,7	847	79,7	7385,1	100,0
Хувь	56,4	31,1	11,5	1,1	100,0	

Хүснэгт 5: Төрийн өмчийн телевизийн төлбөртэй сурталчилгаа (минутаар)

Телевизийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
MUTV	1397,5	595,5	674,5	45	2712,5	79,1
UBS	482	232,5	0,3	0	714,8	20,9
Бүгд	1879,5	828	674,8	45	3427,3	100,0
Хувь	54,8	24,2	19,7	1,3	100,0	

Хүснэгт 6: Хувийн өмчийн телевизийн төлбөртэй сурталчилгаа (минутаар)

Телевизийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
TV5	2117,7	317,7	120	30	2585,4	65,3
TV25	164,5	1135,5	51,2	3,5	1354,7	34,2
TV9	1	14,5	1	1,2	17,7	0,4
Бүгд	2283,2	1467,7	172,2	34,7	3957,8	100,0
Хувь	57,7	37,1	4,4	0,9	100,0	

Хүснэгт 7: Радиогийн төлбөртэй сурталчилгаа (минутаар)

Радиогийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Монголын Үндэсний Радио	2764	1417	670	30	4881	90,8
Улаанбаатар Радио	368	126	0	0	494	9,2
Бүгд	3132	1543	670	30	5375	100,0
Хувь	58,3	28,7	12,5	0,6	100,0	

**Хүснэгт 8:** Хувийн өмчийн сонины төлбөртэй сурталчилгаа ( $\text{дм}^2\text{-аар}$ )

Сонины нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Үнэн	622,2	0	0	0	622,2	64,1
Зууны мэдээ	32,5	62	21,7	0	116,2	12,0
Өдрийн сонин	25,8	36,7	9,7	0	72,2	7,4
Өнөөдөр	20,7	9,3	0	0	30	3,1
Монголын мэдээ	8,8	71,7	0	2,7	83,2	8,6
Хүмүүс	0	19,5	9,1	0	28,6	2,9
Монголчуудын амьдрал	0	18,5	0	0	18,5	1,9
Сэргүүлэг	0	0	0	0	0	0,0
Зиндаа	0	0	0	0	0	0,0
Бүгд	710	217,7	40,5	2,7	970,9	100,0
Хувь	73,1	22,4	4,2	0,3	100,0	

## 2. Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд сурталчилгаа

2004 оны УИХ-ын сонгуулийн кампанийн үеэр төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр далд сурталчилгаа дийлэнх хувийг эзэлж байсан.

**Хүснэгт 9:** Төрийн өмчийн телевизийн далд сурталчилгаа (минутаар)

Телевиз	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
MUTV	5686,5	102	100	0	5888,5	58,2
UBS	3996	194	17	26	4233	41,8
Бүгд	9682,5	296	117	26	10121,5	100,0
Хувь	95,7	2,9	1,2	0,3	100,0	

**Хүснэгт 10:** Төрийн өмчийн радиогийн далд сурталчилгаа (минутаар)

Радиогийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Монголын Үндэсний Радио	4871	60,5	100	0	5031,5	64,7
Улаанбаатар Радио	2742	0	0	0	2742	35,3
Бүгд	7613	60,5	100	0	7773,5	100,0
Хувь	97,9	0,8	1,3	0,0	100,0	

**Хүснэгт 11:** Төрийн өмчийн сонины далд сурталчилгаа (дм-ээр)

Сонины нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд
УБ таймс	412,1	6	0	0	418,1
Бүгд	98,6	1,4	0,0	0,0	100,0
Хувь	412,1	6	0	0	418,1

### 3. Хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд сурталчилгаа

УИХ-ын сонгуулийн үеэр хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр далд сурталчилгаа нь мөн дийлэнх хувийг эзэлж байсан.

Сонгуулийн кампанит ажлын үеэр сонин хэвлэлүүд, ялангуяа өдөр тутмын сонинууд сонгуулийн талаар хөндлөнгийн байр суурийг илэрхийлэх, дүн шинжилгээ хийсэн мэдээлэл, нийтлэл илүү гаргаж байжээ. “Өнөөдөр” сонины сонгуультай холбогдолтой нийтлэлүүд нийт дүнгээрээ харьцангуй тэнцвэртэй байсан төдийгүй сонгуулийн үйл явцад хөндлөнгийн байр сууринаас хандаж тайлбарлахыг хичээсэн өгүүлэл (голдуу сэтгүүлчийн эрэгцүүлэл) байнга нийтэлж байсан.

Мөн “25-р суваг” телевизийн ярилцлага болон бусад нэвтрүүлэгт намуудын тэнцвэрт харьцаа бусад телевизийнхтэй харьцуулахад нэлээн ойролцоо байв.

**Хүснэгт 12:** Хувийн телевизийн далд сурталчилгаа (минутаар)

Телевиз	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
TV9	6975,6	139,1	412	1,5	7528,2	55,9
TV5	1961	75	3	0	2039	15,1
TV25	865	2394	330	323	3912	29,0
Бүгд	9801,6	2608,1	745	324,5	13479,2	100,0
Хувь	72,7	19,3	5,5	2,4	100,0	

**Хүснэгт 13: Хувийн сонини далд сурталчилгаа (дм-ээр)**

Телевиз	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Зууны мэдээ	1436,5	44,8	25,5	1,5	1508,3	23,6
Сэргүүлэг	380,1	56,8	0,7	7,1	444,7	7,0
Хүмүүс	285,5	64,1	27,7	9,7	387	6,1
Өнөөдөр	390	226,6	29,3	27,7	673,6	10,5
Зиндаа	264,2	50,9	0	6,2	321,3	5,0
Монголчуудын амьдрал	236,5	50,1	1,1	6,5	294,2	4,6
Өдрийн сонин	159,9	1345,4	53,8	40,9	1600	25,0
Монголын мэдээ	2,4	1157,5	0	0	1159,9	18,2
Бүгд	3155,1	2996,2	138,1	99,6	6389	100,0
Хувь	49,4	46,9	2,2	1,6	100,0	

**Жишээ: МАХН-ын сонгуулийн кампанийн нээлтийн сурталчилгаа.**

2004 оны 5-р сарын 17-ны орой МАХН-ын сонгуулийн кампанийн нээлтийн ёслол болсон ба МАХН-ын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийг танилцуулж, дараа нь дуу хөгжмийн од, шилдэг хамтлаг оролцсон тоглолтоор үргэлжлэв. Эрх баригч намтай холбоотой энэ том үйл явдлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийн байдлаар сурвалжилж нэвтрүүлэх нь зүйн хэрэг боловч зарим мэдээллийн хэрэгсэл уг арга хэмжээг ашиглан өргөн хүрээтэй сурталчилгаа явуулсан байна.

**TV9 телевиз:**

Нээлтийн арга хэмжээг тус телевиз сурвалжилж мэдээллийн хөтөлбөрөөр үзүүлэхийн зэрэгцээ дараагийн хоёр өдрийн турш тоглолтын бичлэгийг дахин дахин үзүүлэв. Бичлэгийн дундуур МАХН-аас нэр дэвшигч болон МАХН-ыг дэмжсэн сонгогчийн яриаг урьдчилан бэлтгэж монтажлан оруулах зэргээр сурталчилгааны нэвтрүүлэг болгов. Үүнд:

- 17-18-ны шөнө 01,00-02,25 цагийн хооронд (үргэлжлэл 1 цаг 25 минут) дээрх арга хэмжээний зөвхөн эхний буюу нэр дэвшигчийг танилцуулсан хэсгийг үзүүлсэн ба тоглолтын дундуур нэр дэвшигчтэй хийсэн хэдэн арван ярилцлагыг оруулав, Мөн завсраар нь МАХН-ын сурталчилгааны клип (жишээлбэл, тус намаас нэр дэвшигчийн бүрэлдэхүүний тухай тоо баримт, гэрэл зураг бүхий) үзүүлж байв.
- 18-ны өглөө бичлэгийг давтан үзүүлэв.
- 18-ны орой 20,35–24,05 цагийн хооронд 3 цаг 35 минутийн туршид нээлтийн ёслолын бичлэг үзүүллээ. Дуучин, хамтлагийн тоглолтын завсраар МАХН-ын сурталчилгааны клип (“Бид нэг л гэр бүл” гэх мэт), МАХН гэсэн үсэг дэлгэц дээр гарч, МАХН-ыг дэмжсэн

ярилцлагыг үзүүлж байлаа. Мөн тоглолтыг хөтлөгчид хамтлагийг танилцуулахдаа МАХН-ыг магтсан тайлбар хэлж байсныг оруулав. Жишээлбэл, "МАХН их өрийг шийдсэн... иймээс "Харанга" хамтлаг "Москвагийн бороо" дууг дуулна" гэх мэт. Дуучин Д.Жаргалсайхан МАХН-ын төлөө саналаа өгөхийг уриалж байв. Төгсгөлд нь Н.Энхбаяр тоглолтыг хааж МАХН-д санал өгөхийг уриалж үг хэлснийг үзүүллээ.

#### **Монголын Үндэсний телевиз:**


Монголын Үндэсний телевиз энэ арга хэмжээний бичлэгийг 5-р сарын 18-ны оройн "Гэрэлтэй цонх" хөтөлбөрөөр 23.30-01.50 цагийн хооронд, 2 цаг 20 минутийн турш үзүүллээ. Ямар нэгэн оршил, тайлбаргүй, нээлтийн арга хэмжээний эхний хэсэг буюу нэр дэвшигчийн танилцуулга, батламж гардуулах ёслолыг бүрэн үзүүлж харин тоглолтыг бага зэрэг товчилсон байв. Энэ үеэр дэлгэц дээр МАХН-ын улаан сарнай тэмдэг үе үе үзэгдэж дэлгэцийг бүрхээд далд орж байв. Мөн зарим нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагыг тоглолтын дундуур хэд хэдэн хүнээр багцалж, хэд хэдэн удаа оруулав. Ташрамд дурдахад, MYTV-ийн хөтлөгч Цоодол, Чимгээ, Гантигмаа нар энэ арга хэмжээг хөтөлсөн билээ.

Хоёр хоногийн дараа, 4-р сарын 20-нд Монголын Үндэсний телевизийн "Хит" хөгжим мэдээллийн хөтөлбөрөөр нээлтийн ажиллагааг 22.15-23.20 цагийн хооронд 50 минутийн турш дахин үзүүлэв. Дэлгэцийн зүүн доод хэсэгт МАХН-ын улаан сарнайг байнга "зүүжээ". Тоглолтонд оролцсон урлаг соёлын ододоос асуулт асууж тэд ихэнхдээ МАХН-ыг дэмжихээ хэлж байв. Энэ үеэр дэлгэцийг хоёр хувааж нөгөө талд МАХН-аас нэр дэвшигчийн нэр, гэрэл зураг, албан тушаалын жагсаалт урсан гарч байгаагаар үзүүлэв.


УИХ-ын Сонгуулийн тухай хуульд "Улс төрийн намын харьялалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчин уг нээлтийн ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгааны агуулгатайгаар нэвтрүүлэв.

TV9 телевизийн сурталчилгааны албан ёсны тариф нэвтрүүлгийн агуулга, хэлбэрээс хамаараад өөр. МАХН-ын сонгуулийн сурталчилгааны нээлтийн ажиллагаанд шууд таарах тарифийн ангилал байхгүй бөгөөд хамгийн багаар буюу "Нэр дэвшигчийн бэлэн нэвтрүүлэг" гэсэн ангиллаар бүртгэсэн. Ийм нэвтрүүлгийн нэг минут 50000 төгрөг, TV9 телевиз 5-р сарын 17-18-нд энэ үйл явдлыг нийтдээ 6 цаг 25 минут буюу нийт 385 минутын турш үзүүлжээ. Үүнийг төгрөгөөр илэрхийлбэл 19 сая 250 мянган төгрөг, Хэрвээ "намын фон реклам", "Нэр дэвшигчийн реклам" зэргийг нэг секунд нь 3000-4000 төгрөг, нэг минут нь 180000-240000 төгрөгийн тарифаар тооцвол 69,3-92,4 сая төгрөгт хүрч байна. Арга хэмжээг өөрийн техник, тоног төхөөрөмжөөр бичиж сурвалжилсан, сэтгүүлч, уран бүтээлч газар дээр нь очиж нэр дэвшигчээс ярилцлага авсан зэрэг зардлыг оруулаагүй.

Радиогоор нэвтрүүлсэн төлбөртэй болон далд сурталчилгааны динамик



Сонинуудад хэвлэгдсэн төлбөртэй болон далд сурталчилгааны динамик



## 5.3. Хуулийн хэрэгжилт

Сонгуулийн кампанит ажилд төрийн санхүүгийн эх үүсвэрийг ашиглах, тухайлбал, төрийн албан хаагч, төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэрийг ашиглахгүй байх заалт зарим хуульд туссан байдаг. Хэдий тийм боловч дээрх заалт хэрэгждэггүй, түүнийг дагаж мөрддөггүй байна. Хуулийн дээрх заалт зөрчигдсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой бус, цөөн тохиолдолд хүлээлгэж буй хариуцлага нь сул, торгуулийн хэмжээ ч бага байна. Тухайлбал, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн хуулийн санхүүжилтийн журмыг зөрчиж өгсөн, авсан, зарцуулсан хандив, сонгуулийн зардлаас өөр зориулалтаар зарцуулсан хөрөнгө, түүнчлэн тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд үлдсэн хөрөнгийг улсын орлого болгоно гэсэн заалтаас өөр зохицуулалт байхгүй.

УИХ-ын сонгуулийн хуулийн 21 дүгээр зүйлд “Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн өмнөх сурталчилгааны зориулалттай уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг аймагт сумын засаг дарга, нийслэлд дүүргийн засаг даргаас зөвшөөрсөн гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулна” гэсэн заалт байдаг.

Мониторингийн арга хэмжээнд сонгуулийн сурталчилгааны самбар хамраагүй боловч 2004 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар мониторингийн З дүүрэгт байрлах сурталчилгааны самбарыг тоолж, аль нам, эвслийнх болохыг судалж үзсэн. Үүнд:

- Баянгол дүүргийн нэг тойротг 114 сурталчилгааны самбар байснаас 74 нь МАХН-ын, 40 нь Эх орон-Ардчилал эвслийн,
- Сүхбаатар дүүргийн нэг тойротг 60 сурталчилгааны самбар байснаас 54 нь МАХН-ын, 6 нь Эх орон-Ардчилал эвслийн,
- Сонгинохайрхан дүүргийн нэг тойротг 106 сурталчилгааны самбар байснаас 104 нь МАХН-ын, 2 нь Эх орон-Ардчилал эвслийнх байлаа.

Сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд төрийн байгууллагын унаа, төрийн өмчийн байр, төрийн албан хаагчийг ашигласан нь тус мониторингийн дүнгээр илрэн, энэ дүнг олон нийтэд танилцуулж, хуулийг мөрдүүлэх болон хэрэгжүүлж ажиллах үүрэг бүхий байгууллагад тайланг хүргүүлсэн болно, Төрийн эх үүсвэрийг урвуулан ашигласан тохиолдолд эрх бүхий байгууллага болон шүүхээс хариуцлага тооцож, хянан хэлэлцсэн болон шийтгэл ногдуулсан

талаар одоогоор аливаа мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гараагүй байна. Төслийн бацаас дээрх асуудлаар хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлага тооцох эрх бүхий зарим байгууллагад хандан хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцсон эсэхийг лавлахад дараахь хариуг авсан.

Үүнд:

- Төрийн албатай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэдэг эрх бүхий байгууллага болох Төрийн Албаны Зөвлөлд сонгуулийн кампанит ажилд байгууллагын эх үүсвэрийг ашигласан талаархи гомдол, маргаан ирээгүй, энэ талаар хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас дээрх асуудлаар хариуцлага тооцсон тохиолдол Төрийн Албаны Зөвлөлд бүртгэгдээгүй байна.
- Үндсэн Хуулийн Цэцэд сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэрийг урвуулан ашигласан талаархи ямар нэгэн гомдол ирээгүй байна.
- Шүүхэд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд урвуулан ашигласан асуудлаар үүссэн, хянан шийдвэрлэсэн маргаан одоогоор гараагүй бөгөөд 2004 оны хувьд шүүхийн дүн, мэдээг нэгтгээгүй тул энэ талаархи мэдээллийг авах боломжгүй байлаа.
- СЕХ-нд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд урвуулан ашиглаж буй талаар амаар болон бичгээр олон тооны гомдол ирсэн боловч сонгуулийн хууль тогтоомжоор энэ тухай зохицуулаагүй тул СЕХ-ны эрх хэмжээнд хамаarahгүй асуудал гэсэн байр сууринеас ханджээ.

Сонгуулийн кампанит ажлын хугацаанд хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, зөрчлийг таслан зогсоох, холбогдох этгээдэд хариуцлага тооцож ажиллахыг хүссэн олон тооны албан бичгийг нам, нэр дэвшигч СЕХ-нд хүргүүлж байсан. Тухайлбал СЕХ-нд хандан Эх орон-Ардчилал эвслээс ирүүлсэн албан тоотод:

- 2004 оны 5 сарын 24-ний 6 тоот албан бичигт “тус эвслээс нэр дэвшигч сурталчилгаа хийхэд төр засгийн байгууллага янз бүрийн саад учруулж, тэр ч бүү хэл хөндлөнгөөс ил далд аргаар эрээ цээргүй оролцож байна. Тухайлбал, 66 дугаар тойрогт нэр дэвшигч Б.Батбаатар сурталчилгааны самбар хийлгэх талаар хувийн компанийтай гэрээ байгуулан ажиллаж байхад эрх баригчид уг компанийд дарамт үзүүлж гэрээгээ цуцлахыг шаардсан байна. Мөн нам эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны ажилд нийт татвар төлөгчийн мөнгөөр санхүүждэг төрийн байгууллагын оролцоог болиулах, таслан зогсоох талаар холбогдох арга хэмжээ авна уу” гэжээ.

- 2004 оны 5 сарын 31-ний 10 тоот албан бичигт “Төр захиргааны байгууллагын дарга, ажилтан МАХН-аас нэр дэвшигчийн сурталчилгаанд ажиллаж, улсын эд хөрөнгө ашиглах зөрчил гарсаар байна. Ийнхүү сонгуулийн хууль тогтоомжийг зөрчиж байгаа хууль бус үйл ажиллагааг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу таслан зогсоож, сонгууль шударга явах нөхцөлийг бүрдүүлэхийг шаардаж байна” гэжээ.
- 2004 оны 6 сарын 22-ын өдрийн 45 тоот албан бичигт “Эрх баригчид СЕХ-ноос баталж өгсөн үндэсний телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа явуулах хуваарийг үл хүндэтгэн дуртай цагтаа сурталчилгаа, эрээ цээргүй гүтгэлэг явуулж байгааг таслан зогсоож, өөрийн баталсан дүрэм журмаа мөрдүүлнэ үү, Эрх баригчид сонгуулийн сурталчилгаандаа төрийн олон зуун албан хаагчид унаа машиныг ашиглаж байгаа нь УИХ-ын сонгуулийн хууль, Төрийн албаны хууль, Авилгалын эсрэг хуулийг ноцтой зөрчиж байгааг анхаарч энэхүү хууль бус үйлдлийг нэн даруй таслан зогсоох талаар Төрийн хянан шалгах хороо болон холбогдох бусад байгууллагатай хамтран арга хэмжээ авах” гэж дурджээ.
- 2004 оны 6 сарын 24-ний 53 тоот албан бичигт “УИХ-ын сонгуулийн 37 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшигч Ц, Сүхбаатар өөрийн сонгуулийн сурталчилгаанд орон нутгийн төдийгүй улсын Нийгмийн даатгалын газрын ажилтныг өргөнөөр оролцуулж байгаа талаар бид урьд нь мэдэгдэж байсан, Гэтэл өнөөдөр тус тойргоос ирсэн мэдээллээр Төв аймгийн Эрдэнэсант суманд Улаанбаатар хотын Нийгмийн даатгалын газрын 140-150 ажилтан Ц, Сүхбаатарын сурталчилгаанд ажиллаж, саналаа өгөхөөр очсон байна” гэж тэмдэглэжээ.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос гаргасан “Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” мониторингийн судалгааны тайланд дурдсанаар, СЕХ-нд 2004 онд ирсэн УИХ-ын сонгуулийн зөрчил гомдлын талаархи 600 орчим баримт материалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд сонгуулийн үмнийх ухуулга сурталчилгааны зөрчил буюу хуулийн 21 дүгээр зүйл 23 удаа буюу нэлээд их бүртгэгдсэн байна, Мөн тайланд „„улс төрийн сонгуульд хүний сонгох эрхийг зөрчих нь нийгмийн институцийг хамарч, зохион байгуулалтын шинжтэй болж байгааг илчилж байна, Ийм нөхцөл байдал сонгуулийн хуулийн 6 дугаар зүйл, орон нутгийн сонгуулийн хуулийн 23 дугаар зүйлийн 6 дахь заалтыг зөрчсөн бөгөөд дээрх үйлдлийг гаргасан этгээдийг 40000-50000, нам, эвсэл, талархан дэмжигч этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгохоор хуульд заасан байдаг, Аливаа хуульд хийхээр завдсан үйлдэл ба эс үйлдэлд

хариуцлага хүлээлгэх үндэслэл бий. Гэтэл өнгөрсөн сонгуулийн хугацаанд дээрх зүйл заалтын дагуу хуулийн хариуцлага хүлээсэн нэг ч нэр дэвшигч, улс төрийн нам байхгүй,” тухай тэмдэглэсэн байна.

СЕХ-ны тайлангаас үзвэл нам, эвсэл сонгуулийн зардлын санд аж ахуйн нэгж байгууллага, иргэний хандивын 54,9 хувийг бэлнээр авч, нийт зардлын 65,6 хувийг бэлэн мөнгөөр гүйцэтгэжээ. УИХ-ын Сонгуулийн хуулийн 5-р зүйлийн 5-р хэсэгт „„Энэ дансанд тухайн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, талархан дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж мөн дансаар дамжуулан зарцуулна” гэсэн заалтыг зөрчиж бүх нам, эвсэл хандивыг бэлнээр авах явдал гарсан байна. Түүнчлэн “Эх орон-Ардчилал” эвсэл иргэний хандивласан 1333,4 сая төгрөгөөс 241,9 сая төгрөгийг сонгуулийн зардлын санд төвлөрүүлэн зарцуулж, харин 1091,5 сая төгрөгийг юунд зарцуулсан нь тодорхойгүй байна.

МҮЭНН, МЛН, МБНН, МНН УИХ-ын сонгуулийн зардлын сангийн бүрдүүлэлт зарцуулалтын тайланг хуульд заасан хугацаанаас 6-33 хоногоор хожимдуулан ирүүлсэн тул тэдний дансанд үлдсэн мөнгийг улсын орлого болгохоор шийдвэрлэжээ.

Мөн бие даан нэр дэвшигч тус бүр 4-51,4 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд тэдний дийлэнх банкинд сонгуулийн зардлын сангийн данс нээлгүйгээр хандивыг бэлнээр авч, зарцуулсан нь хууль зөрчсөн үйлдэл болжээ.

## 5.4. Санхүүгийн тооцоо ба үр нөлөө

### 1. Сонгуулийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоо

Хэвлэл мэдээллийн мониторингийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан сонгуулийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоог гарган, мөнгөн дүнгээр илэрхийлж гаргасан.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан нийт сонгуулийн төлбөртэй сурталчилгааг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1140,1 сая төгрөг болж буй бөгөөд үүний төрийн өмчийн хэвлэл мэдээллээр гарсан нь 798,2 сая төгрөг буюу 70 хувь болж байна. Харин хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд 342,2 сая төгрөг буюу 30 хувь болж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан сонгуулийн төлбөртэй сурталчилгааг намуудаар харуулбал МАХН 656,4 сая төгрөг буюу 57,5%, “Эх орон-Ардчилал” Эвсэл 304,9 сая төгрөг буюу 26,7%, бусад нам 166,3 сая төгрөг буюу 14,5%, бие даан нэр дэвшигчид 12,5 сая төгрөг буюу 1% эзэлж байна.

Хүснэгт 14. Төлбөртэй сурталчилгааны үнэ (сая төгрөгөөр)

	TV	Радио	Сонин	Бүгд	Хувь
МАХН	507,4	140,8	8,2	656,4	57,5
Эх орон-Ардчилал эвсэл	229,4	71,7	3,8	304,9	26,7
Бусад нам	132	33,5	0,8	166,3	14,5
Бие даан нэр дэвшигч	11	1,5	0	12,5	1
Бүгд	879,8	247,5	12,8	1140,1	100

Хүснэгт 15: Төрийн өмчийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)

	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Нийт үнэ	Хувь
MUTV	243,2	103,6	117,4	7,8	472	85,7
UBS	53	25,6	0	0	78,6	14,3
Бүгд	296,2	129,2	117,4	7,8	550,6	100,0
Хувь	53,8	23,5	21,3	1,4	100,0	

Хүснэгт 16: Хувийн өмчийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)

Телевизийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
TV5	201,2	30,2	11,4	2,9	245,7	27,9
TV25	9,9	68,1	3,1	0,2	81,3	9,2
TV9	0,1	1,9	0,1	0,2	2,3	0,3
Бүгд	211,2	100,2	14,6	3,3	329,3	100,0
Хувь	64,1	30,4	4,4	1,0	100,0	

Хүснэгт 17: Радиогийн төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)

Радиогийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Монголын Үндэсний Радио	138,2	70,9	33,5	1,5	244,1	98,6
Улаанбаатар Радио	2,6	0,9	0	0	3,5	1,4
Бүгд	140,8	71,8	33,5	1,5	247,6	100,0
Хувь	56,9	29,0	13,5	0,6	100,0	

**Хүснэгт 18: Хувийн өмчийн сонины төлбөртэй сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)**

Сонины нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Үнэн	6,7	0	0	0	6,7	51,9
Зууны мэдээ	0,5	1	0,4	0	1,9	14,7
Өдрийн сонин	0,4	0,6	0,2	0	1,2	9,3
Өнөөдөр	0,4	0,2	0	0	0,6	4,7
Монголын мэдээ	0,1	1	0	0	1,1	8,5
Хүмүүс	0	0,7	0,3	0	1	7,8
Монголчуудын амьдрал	0	0,4	0	0	0,4	3,1
Сэргүүлэг	0	0	0	0	0	0,0
Зиндаа	0	0	0	0	0	0,0
Бүгд	8,1	3,9	0,9	0	12,9	100,0
Хувь	62,8	30,2	7,0	0,0	100,0	

**2. Сонгуулийн арга хэмжээнд урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийн санхүүгийн тооцоо**

**Төрийн унаа ашигласан өртөг**

Ажигласан арга хэмжээний 295 нь МАХН-ынх бөгөөд төрийн унаа ашигласан нийт км нь 50316 км байна. Үүний санхүүгийн тооцоог гаргахдаа тайлангийн 2.1. хэсэгт заасан аргачлалын дагуу гаргав.

Нийт арга хэмжээ /295/-ний өртөг	50316км x 410 төг = 20,629,560 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон өртөг	20,629,560 төг / 295 = 69930 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	69930 төг x 80 = 5,594,400 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	5,594,400 төг x 76 = 425,174,400 төгрөг

Ажигласан арга хэмжээний 243 нь Эх орон-Ардчилал эвслийнх бөгөөд нийт км нь 1050 км байна, Үүний санхүүгийн тооцоог гаргавал:

Нийт арга хэмжээ /243/-ний өртөг	1050 км x 410 төг = 430,500 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон өртөг	430,500 төг / 243 = 1772 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	1772 төг x 80 = 141,760 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	141,760 төг x 76 = 10,773,760 төгрөг

### Төрийн өмчийн байр ашигласан өртөг

Ашигласан арга хэмжээний 295 удаагийн арга хэмжээ МАХН-ынх бөгөөд нийт төрийн өмчийн байрыг үнэ төлбөргүй ашигласан цаг 507 юм. Үүний санхүүгийн тооцоог гаргахдаа тайлангийн 2.1. хэсэгт заасан аргачлалын дагуу гаргав.

Нийт арга хэмжээ /295/-ний өртөг	507 цаг х 56660 төг = 28,726620 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон ортог	28,726,620 төг / 295 = 97378 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	97378 төг х 80 = 7,790,240 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	7,790,240 төг х 76 = 592,058,240 төгрөг

Ашигласан арга хэмжээний 243 нь Эх орон-Ардчилал эвслийн арга хэмжээ бөгөөд төрийн өмчийн байрыг үнэ төлбөргүй ашигласан цаг 99 юм. Үүний санхүүгийн тооцоог гаргавал:

Нийт арга хэмжээ /243/-ний өртөг	99 цаг х 56660 төг=5,609,340 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон ортог	5,609,340 төг / 243 = 23084 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	23084 төг х 80 = 1,846,720 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	1,846,720 төг х 76 = 140,350,720 төгрөг

### Төрийн албан хаагч ашигласан өртөг

Төрийн албан хаагчийг сонгуулийн кампанид ашигласан өртгийг тооцохдоо цалингийн жишгээр тооцон нэг цагийн өртгийг хамгийн бага жишгээр буюу 1000 төгрөгөөр тооцов. Санхүүгийн тооцоог гаргахдаа тайлангийн 2.1. хэсэгт заасан аргачлалын дагуу гаргав.

МАХН-ын хувьд:

Нийт арга хэмжээ /295/-ний өртөг	7720 цаг х 1000 төг = 7,720,000 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон өртөг	7,720,000 төг / 295 = 26170 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	26170 төг х 80 = 2,093,600 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	2,093,600 төг х 76 = 222,725,600 төгрөг

Эх орон-Ардчилал эвслийн хувьд:

Нийт арга хэмжээ /243/-ний өртөг	78 цаг х 1000 төг = 78,000 төгрөг
Нэг удаагийн арга хэмжээнд тооцсон өртөг	78,000 төг / 243 = 321 төгрөг
Нэг тойротг тооцсон өртөг	321 төг х 80 = 25,680 төгрөг
Үндэсний хэмжээнд тооцсон өртөг	25,680 төг х 76 = 1,951,680 төгрөг

### 3. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн далд сурталчилгааны санхүүгийн тооцоо

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлбөртэй сурталчилгааны тарифыг үндэслэн төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд сурталчилгааны санхүүгийн тооцоог гарган, урвуулан ашигласан хэвлэл мэдээллийн эх үүсвэрийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн болно.

Төрийн эх үүсвэрийг урвуулан ашигласан байдлыг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1 тэр бум 764,4 сая төгрөг болж байгаа ба үүнийг намаар харуулбал MAXH 1695,1 сая, Эх Орон-Ардчилал 42,1 сая, бусад нам 24,3 сая, бие даан нэр дэвшигч 2,9 сая төгрөг болж байна. Төрийн өмчийн хэвлэл мэдээллээр явуулсан нийт сурталчилгааны дийлэнх буюу 96,1 хувь нь MAXH, түүний нэр дэвшигчдэд оногдож байна.

**Хүснэгт 19 : Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн далд сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)**

	MAXH	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Төрийн өмчийн телевиз	1429,1	39	19,3	2,9	1490,3	84,5
Төрийн өмчийн радио	262,7	3	5	0	270,7	15,3
Төрийн өмчийн сонин	3,3	0,1	0	0	3,4	0,2
Бүгд	1695,1	42,1	24,3	2,9	1764,4	100,0
Хувь	96,1	2,4	1,4	0,2	100,0	

**Хүснэгт 20: Төрийн өмчийн телевизийн далд сурталчилгааны санхүүгийн тооцоо**

Телевиз	MAXH	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
MUTV	989,5	17,7	17,4	0	1024,6	68,8
UBS	439,6	21,3	1,9	2,9	465,7	31,2
Бүгд	1429,1	39	19,3	2,9	1490,3	100,0
Хувь	95,9	2,6	1,3	0,2	100,0	

**Хүснэгт 21:** Төрийн өмчийн радиогийн далд сурталчилгааны санхүүгийн тооцоо (сая төгрөгөөр)

Радиогийн нэр	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Бүгд	Хувь
Монголын үндэсний Радио	243,6	3	5	0	251,6	92,9
Улаанбаатар Радио	19,2	0	0	0	19,2	7,1
Бүгд	262,8	3	5	0	270,8	100,0
Хувь	97,0	1,1	1,8	0,0	100,0	

**Хүснэгт 22:** Төрийн өмчийн сонинь далд сурталчилгааны санхүүгийн тооцоо(сая төгрөгөөр)

Сонин	МАХН	Эх орон - Ардчилал эвсэл	Бусад нам	Бие даан нэр дэвшигч	Нийт
УБ таймс	3,3	0	0	0	3,3
Хувь	100	0	0	0	100

#### 4. Нийт урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийн санхүүгийн тооцоо

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн эх үүсвэрийг урвуулан ашигласан байдлыг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1 тэр бум 764,4 сая төгрөг болж байна. Харин төрийн өмчийн байр, унаа болон төрийн албан хаагч ашигласан байдлын санхүүгийн тооцоог гаргавал нийтдээ 1 тэр бум 393,3 сая төгрөг болж байна. Үүнийг нэгтгэн харуулбал 3 тэр бум 157,7 сая төгрөг болж байгаа нь 2004 оны УИХ-ын сонгуулиар нийт урвуулан ашиглагдсан төрийн эх үүсвэрийн мөнгөн дүн юм. Эдгээр дүнг намаар харуулбал МАХН 2,935,058,240 төгрөг, Эх Орон-Ардчилал 195,176,160 болж байна.

#### 5. Сонгуулийн зардлын сангийн зарцуулалтын тайлантай харьцуулах нь.

УИХ-ын сонгуулийн хуульд зааснаар, нам эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын сангийн зарцуулалтын тайланг сонгууль дууссан өдрөөс хойш нэг сарын дотор СЕХ-нд хүргүүлж, СЕХ уг тайланг хянан үзэж нэгтгээд олон нийтэд зарладаг журамтай. 2004 оны УИХ-ын сонгуульд оролцсон улс төрийн нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг СЕХ 9-р сарын 17-ны өдөр нийтэд зарласан билээ.

СЕХ-ны албан мэдээнд дурдсанаар, сонгуульд оролцсон бүх нам, эвсэл банкинд данс нээж, нийтэд зарлан уг дансанд сонгуулийн зардлын санг төвлөрүүлэн зарцуулжээ. Нам, эвслээс ирүүлсэн тайлан, СЕХ-ны дэргэдэх Сонгуулийн санхүүгийн хяналтын албанаас хийсэн шалгалтын дүнгээс үзвэл сонгуульд оролцсон нам, эвсэл зардлын сандаа 1560,7 сая төгрөг төвлөрүүлж, 1558,4 сая төгрөг зарцуулсан байна.

СЕХ-нд өгсөн албан ёсны тайлангаар 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажилд нийт 1,187,493,8 мянган төгрөгийг MAXH, 241,887,9 мянган төгрөгийг Эх орон-Ардчилал эвсэл зарцуулснаар тайлагнасан байна. Албан ёсны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс мониторингийн зардал тооцсон үзүүлэлттэй харьцуулж болох дүнг жагсаавал:

**МАХН-ын хувьд:**

- Сонгогчтой хийх уулзалт, үдэшлэгт 141,630,1 мянган төгрөг
- Цалингийн зардалд 36,645,0 мянган төгрөг
- Унааны зардалд 315,133,0 мянган төгрөг

Нийт: 493,408,1 мянган төгрөг

**Эх орон-Ардчилал эвслийн хувьд:**

- Сонгогчтой хийх уулзалт, үдэшлэгт 9,058,0 мянган төгрөг
- Цалингийн зардалд 20,898,3 мянган төгрөг
- Унааны зардалд 4,392,0 мянган төгрөг

Нийт: 34,348,3 мянган төгрөг

СЕХ-нд өгсөн намуудын санхүүжилтийн тайлангийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

Мониторингийн дүнгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан намуудын сонгуулийн төлбөртэй сурталчилгаа нь MAXH 656,4 сая төгрөг, “Эх орон-Ардчилал” Эвсэл 304,9 сая төгрөг, бусад нам 166,3 сая төгрөг, бие даан нэр дэвшигчид 12,5 сая төгрөг байна. Үүнийг намуудын СЕХ-нд өгсөн санхүүжилтийн тайлантай харьцуулахад “Эх орон-Ардчилал” Эвсэл 1,531,232 төгрөг, MAXH 785287,5 төгрөг байгаа нь нэлээд зөрүүтэй байгааг харуулж байна.

Мониторингийн дүнгээр сонгуулийн арга хэмжээнд ашигласан төрийн өмчийн байр, төрийн унаа, төрийн албан хаагчийн барагцаалан тооцсон дүнг намаар харуулбал MAXH 1,239,958,240 төгрөг, “Эх орон-Ардчилал” Эвсэл 153,076,160 төгрөг болж байна. СЕХ-нд өгсөн албан ёсны тайлангаар 2004

оны УИХ-ын сонгуулийн кампанит ажилд сонгогчтой хийх уулзалт, үдэшлэг, цалин, унааны зардалд МАХН 493,408,1 мянган төгрөг, Эх орон-Ардчилал эвслийн хувьд 34,348,3 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнажээ.

Төрийн өмчийн хэвлэл мэдээллийг далд сурталчилгааны хэлбэрээр ашигласан дүнг намаар харуулбал МАХН 1,695,100,000 төгрөг, “Эх орон-Ардчилал” Эвсэл 42,100,000 төгрөг болж байна.

#### ***Шигтгээ. Төрийн эх үүсвэрийн урвуулан ашигласан хэмжээ.***

“Өдрийн сонин”-д “ төсвийн нийт тэнцэл 1.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ” гэсэн гарчигтай Засгийн газрын ээлжит хуралдааны талаархи мэдээ нийтлэгдсэн байсан. Энэхүү дүн нь 2004 оны УИХ-ын сонгуулийн урвуулан ашигласан төрийн эх үүсвэрийн дүнтэй ойролцоо дүн юм. Төсвийн 1.4 тэрбум төгрөгийн алдагдлыг сонгуулийн кампанид ашигласан гэж дүгнэх боломжгүй, харин ашиглагдсан төрийн эх үүсвэрийн тодорхой хэмжээгээр харьцуулан харуулах жишээ болж буй юм.

## VI. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 6.1. ТОВЧ ДҮГНЭЛТ

Энэхүү мониторингийн үр дүн дээр үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1. 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр байгууллагын нөөц болон хэвлэл мэдээллийн нөөц сонгуулийн кампанид их хэмжээгээр ашиглагдсан байна. Сонгуулийн кампанит ажилд төрийн унаа болон төрийн албан хаагчийг илүү ашигласан байна. Сонгуулийн кампанит ажилд төрийн албан хаагч их хэмжээгээр ашиглагдсан нь төрийн алба, үйлчилгээг цалгардуулжээ. Сонгуулийн арга хэмжээнд ашигласан төрийн эх үүсвэрийн нийт дүнг барагцаалан тооцоход нийтдээ 1,393,034,400 төгрөг болж буй бөгөөд намаар харуулбал МАХН 1,239,958,240 төгрөг, “Эх орон-Ардчилал” Эвсэл 153,076,160 төгрөг болж байна.
2. Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрх барьж буй намын сурталчилгаанд хамгийн их ашиглагдсан байна. Нийт төрийн өмчийн хэвлэл мэдээллийг ашигласан дүн 1,737,200,000 төгрөг болж буй бөгөөд намаар харуулбал МАХН 1,695,100,000 төгрөг, “Эх орон-Ардчилал” Эвсэл 42,100,000 төгрөг болж байна.
3. УИХ-ын сонгуулийн үеэр хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тэнцвэртэй мэдээлэл түгээх талаар дутагдалтай ажилласан байна.
4. СЕХ-нд өгсөн албан ёсны тайлангаар 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажилд нийт 1,187,493,8 мянган төгрөгийг МАХН, 241,887,9 мянган төгрөгийг Эх орон-Ардчилал эвсэл зарцуулснаар тайлагнасан байна. Үүнээс сонгогчтой хийх уулзалт, үдэшлэг, цалин, унааны зардалд МАХН 493,408,1 мянган төгрөг, Эх орон-Ардчилал эвслийн хувьд 34,348,3 мянган төгрөг зарцуулсан гэж тайлагнажээ. Энэхүү дүнг мониторингийн үзүүлэлттэй харьцуулахад “Эх орон-Ардчилал” Эвсэл 1,531,232 төгрөг, МАХН 785287,5 төгрөг байгаа нь зөрүүтэй байгааг харуулж байна.
5. Сонгуулийн кампанит ажлын хугацаанд УИХ-ын сонгуулийн хууль, Авилгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зэрэг хуулийг зөрчсөн олон тохиолдол гаржээ.

6. Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах нь тодорхой нам, нэр дэвшигчийн буруутай, санаатай үйлдэл байхаас илүүтэй ийм зөрчлийг бий болгодог улс төрийн тогтолцооны дутагдал болохыг мониторингийн дүн харуулж байна. Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах боломжийг хязгаарласан хууль эрх зүйн орчин, хэрэгжих механизм байхгүй үед аль ч эрх баригч нам, эвслийн үед энэхүү байдал давтагдах юм.

## 6.2 Төрийн эх үүсвэрийг урвуугаар ашигласан хүчин зүйл

Төрийн эх үүсвэрийг урвуугаар ашиглах боломж олгож буй хүчин зүйл нь улс төрийн хүчин зүйл буюу нэг нам дангаараа эрх барьж буй явдал байхаас гадна хууль эрх зүйн зохицуулалт нь ийм боломжийг бий болгож байна. Ялангуяа, сонгууль, төрийн алба, хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомж сул, болон эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн механизм сул эсвэл огт байдаггүй байна.

Мониторингийн дүнгээр хууль эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сул бөгөөд цаашид шинэчлэл хийх шаардлагатай дараах чиглэлүүдийг гаргалаа.

1. Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд ашиглахыг хориглосон хуулийн зохицуулалт дутагдалтай байдаг. Сонгуулийн арга хэмжээнд төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглахыг хориглосон заалт огт байхгүй ба хэвлэл мэдээллийг ашиглах талаарх заалт нь сул байдаг.
2. Төрийн эх үүсвэрийг албаны бус зорилгод ашигласан тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлага сул, хэрэгжих механизм байхгүй.
3. Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоо болон сонгуулттай холбогдох зөрчил, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа нь тодорхой бус.
4. СЕХ-ны бие даасан, хараат бус байдал хангагдаагүй.
5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн хяналтанд байдаг.
6. Улс төрийн намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг олон нийтэд нээлттэй байлгах тухай хуулийн зохицуулалт байхгүй.

## 6.3 Зөвлөмж

Сонгуулийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

1. Сонгуулийн тухай хууль тогтоомжуудад төрийн албан хаагчид сонгуулийн сурталчилгаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох эсвэл тодорхой нам, нэр дэвшигчийг дэмжих, эс дэмжихийг уриалахыг хориглосон зохицуулалтыг оруулах. Түүнчлэн, нэр дэвшсэн төрийн албан хаагч нь төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр болон төрийн албан хаагчдыг ашиглахыг хориглосон заалтыг оруулах;
2. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн эх үүсвэр, орлого зарлагын жилийн тайланг нээлттэй, ил тод болгохыг хуулиар зохицуулан, олон нийтэд нээлттэй болгох;
3. Төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид урвуулан ашигласан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, тухайлбал, энэхүү зөрчил нь тогтоогдсон бол зөрчил үйлдсэн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах хүртэл хариуцлага тооцох;
4. Нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн хандив, сонгуулийн кампанит ажлын орлого, зарлагад хөндлөнгийн хяналт тавьж, олон нийтэд тайлагнах. Тайланг хэнд тавих, ямар мэдээлэл агуулах, тайлан тавих хугацаа, үе шат, тайлан мэдээллийг олон нийтэд хүргэх, тайлагнах явцыг нарийвчлан тусгах;
5. Хувь хүн, албан байгууллага, аж ахуйн нэгжээс улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч нарт өгөх мөнгөн болон мөнгөн бус хандивт хязгаар тогтоох;
6. Сонгуулийн кампанит ажил болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой асуудлыг шалгах, хариуцлага тооцох эрх бүхий санхүүгийн хяналтын үр нөлөөтэй механизм бий болгох;
7. Сонгуулийн кампанит ажлын тодорхойлолтыг боловсронгуй болгон сонгуулийн кампанийн арга хэмжээнд тооцогдох арга хэмжээг нарийвчлан тодорхойлох;
8. Сонгуулийн кампанит ажлын үеэр хууль зөрчсөн, зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, механизм сул байгааг чангатгах ;

Сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мөрдүүлэх;

1. Улс төрийн нам, нэр дэвшигч нь сонгуулийн кампанийн санхүүжилтийн орлого, зарлагын дэлгэрэнгүй тайланг СЕХ-нд өгөх.

- түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгуулийн сурталчилгаанаас олсон орлогын тайланг СЕХ-нд өгөх. Эдгээр тайлан болон үүнийг хянан шалгасан тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг СЕХ хүлээдэг байх;
2. СЕХ болон сонгуулийн бусад хороодын бие даасан хараат байдлыг хангаж, дотоод хяналт бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулах зэрэг сонгуулийн хороог бүрэлдүүлэх журам болон томилгооны шалгуурыг шинэчлэх. Тухайлбал, бүрэлдэхүүнд нь нэг нам, эвслийн төлөөлөл давамгайлахыг хориглох;
  3. Сонгууль зохион байгуулдаг байгууллага улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгуульд оролцохоор бүртгүүлэхэд сонгуулийн хуулийн эрх үүргийг сануулж, ямар тохиолдолд шүүхэд гомдол гаргадаг болохыг танилцуулах ;
  4. Сонгуультай холбоотой гомдол гаргах журмыг боловсронгуй болгох.

#### **Хэвлэл мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгох**

- 1. Сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох;**

УИХ-ын сонгуулийн хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай буюу сонгуулийн бүх хуульд дараахь заалтыг тусгах шаардлагатай. Үүнд:

- Олон нийтээс санхүүждэг өргөн нэвтрүүлэг болон хувийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь сонгуулийн нэвтрүүлгийг шударга, тэнцвэртэй, аливаа ялгаваргүй байдлаар явуулах шаардлагыг тусгах,
- Улс төрийн төлбөртэй сурталчилгааг улс төрийн бодлого, намын харьяаллыг харгалзахгүйгээр төлбөрийн болон цагийн нөхцөл адил тэгш байх үндсэн дээр ялгаварлан гадуурхахгүй олгох,
- Нам, нэр дэвшигчийн улс төрийн төлбөртэй сурталчилгааг олон нийтэд ойлгомжтой, тодорхой байлгах,
- Сонгуулийн кампанийн явцад тодорхой мэдээллийг няцаах боломжийг нам, нэр дэвшигчигчдэд олгох,
- Олон нийтийн мэдээллийн байгууллага сонгуулийн зохих хугацаанд сонгогчийн боловсролд зориулсан /аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаархи сурталчилгаа бус/ мэдээлэл олгох үүрэгтэй байх.

## 2. Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг олон нийтийн болгох

- Монголын Үндэсний телевиз, радиог төрийн мэдлээс гаргаж, хараат бус байдлыг эрх зүйн хувьд баталгаажуулж олон нийтэд үйлчлэх статустай болгох,
- UBS телевиз, “Улаанбаатар” радиог хувьчлах, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байж болох тухай заасныг 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний хуулиар, төрийн байгууллага дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглосон заалтанд нийцүүлэн өөрчлөх,
- Орон нутгийн буюу аймаг, сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын дэргэдэх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, юуны өмнө телевиз, радиогийн асуудлыг дээрх зарчмаар шийдэх.

## 3. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бий болгох

- Олон улсын практик, туршлагыг үндэслэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчтэй холбоотой зөрчил маргааныг дотооддоо үр дүнтэй шийдвэрлэдэг механизмыг бий болгох,
- Сонгуулийн үеэр сэтгүүлчдийн дагаж мөрдөн, баримтлан ажиллах зарчим бий болгох,
- Хэвлэл мэдээллийн байгууллага аливаа шахалт дарамтаас чөлөөтэй байх байдлыг баталгаажуулах, редакцийн хараат бус байдлын статусыг бий болгох.

## 4. Сонгуулийн сурталчилгаанд тавих хяналтыг боловсонгуй болгох

- Сонгуулийн нэвтрүүлэгтэй холбоотой аливаа үүрэг нь СЕХ-ны дэргэдэх хараат бус хэвлэл мэдээллийн зөвлөлөөр хянагдаж байх. Энэ хэвлэл мэдээллийн зөвлөл нь намууд болон нэр дэвшигчдийн гомдолд татгалзах эсхүл хариу өгөх, залруулга хийхийг хэвлэл мэдээллийн байгууллагаас шаардах бүрэн эрхтэй байх.

## 5. Өргөн нэвтрүүлгийн бодлогыг бий болгох

- Радио долгионы болон Харилцаа холбооны тухай хуулинд харилцаа холбооны асуудлыг эрхэлсэн Зохицуулах хорооны хараат бус байдлыг нарийвчлан баталгаажуулах,

- Радио долгионы болон Харилцаа холбооны тухай хуульд өргөн нэвтрүүлгийн нийтлэг бодлогын тухай заалт нэмж тусгах, Зохицуулах хороонд энэ бодлогыг хэрэгжүүлэх үүрэг ногдуулах,
- Зохицуулах хорооны гишүүнийг олон намын төлөөлөлтэй парламентын хороо зэрэг төлөөллийн байгууллагаас томилох, энэ үйл явцыг нээлттэй, олон нийтийг оролцуулан явуулдаг болгох талаар заах,

## **6. Өргөн нэвтрүүлгийн лиценз олгох болон хянах үйл ажиллагааг боловсронгуй болгох**

- Лиценз авах өргөдлийг сонгон шалгаруулахдаа шударга шийдвэр гаргах, олон нийтийн сонирхолд нийцүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор шалгуур үзүүлэлт тогтоох,
- Лиценз олгох үйл явц ил тод, олон нийтэд нээлттэй байх,
- Лиценз олгогч байгууллага нь өргөн нэвтрүүлэг эрхлэгч болон байгууллага нь хууль болон лиценцэд заасан нөхцлийг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавин, зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага оногдуулах үр нөлөөтэй механизмыг бий болгох.

2004 оны УИХ-ЫН СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН САНХУУЖИЛТИЙН ТУХАЙ  
СЕХ-Ноос нийтлүүлсэн албан ёсны дүн мэдээ

## ХАВСРАЛТ

Үзүүлэлтүүд		Мүнх-н	"Эх аюулн" Адьислан" засалт	МАНН	МНН	МНН	МНН	МНН	Дүн
Онолого	Берийн	Баян бус	7500.0		426733.7				437233.7
	Баян	Баян бус		402040.3	500000.0	6763.4	43000.0*		463133.7
	Байгууллагас	Баян бус		28420.5			1000.0	2000.0	29400.5
	Баян	Баян			65309.0				65309.0
	Иргээс	Баян бус		7408557	65744.0		5700.0		208299.7
	Иргээн	Баян	46000.0	46037.9	160051.4		1.0		7249.5
	Буга	Баян	52500.0	241893.0	1180238.0	5000.0	1204.4	5000.0	9249.5
Зарлагын	Сургалчныг таа	Баян бус	6350.0	48005.0	342140.4			6000.0	1500070.4
	Баян	Баян	17400.0	1482267	443147.1	25000.0	8360.0	2700.0	900.0
	Сонгочидай	Баян бус			356590.1				643753.8
	Баян	Баян	9056.0	301023.2	5000.0	5000.0	100.0	150.0	50870.2
	Улааншлаг,	Баян бус			63018.8				83918.8
	Баян	Баян			5849.0	116178.7	4000.0	40.0	125168.7
	Албан томилогт	Баян бус			582.0				582.0
	Баян	Баян			1892.5	16853.0		1800.0	410.0
	Шүүдэн	Баян бус			1241.0	8489.2			1.5
	Баян	Баян	1600.0	1347.4	8888.0	1000.0			7731.7
	Бийнг хэрэг	Баян бус			688.0				12813.4
	Баян	Баян	1413.0	10470.2				200.0	50.0
	Цагийн	Баян бус			2593.0				207555
	Баян	Баян	21600.0	20898.3	34052.0	2000.0	1800.0	400.0	888.8
	Унааны зардалт	Баян бус			898.3				12133.2
	Баян	Баян	4200.0	4382.0	30817.0	13000.0	1844.0	100.0	2593.0
	Бусад	Баян бус			80.0				80.0
	Баян	Баян	1200.0	827.0	18718.0				20545.0
	Буга	Баян	52350.0	241887.9	1187493.8	50000.0	12474.0	5300.0	6851.0
	Дансны улсынзалт		150.0	5.7	1745.3		20.4		308.5
									2319.9

## МОНИТОРИНГИЙН КАЛЕНДАР

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Басан	Бямба	Ням
4-р сар	5	6	7	8 Сонгуулийн ёдрийг ашибан ёсзор зарлах	9	10	11
4-р сар	12	13	14	15	16	17	18
4-р сар	19	20	21	22	23 Төслийн нээлт, танилцуулга уулзант	24	25
4,5-р сар	26	27	28	29	30	1	2
5-р сар	3	4	5	6	7	8	9
5-р сар	10	11	12	13	14	15	16
5-р сар	17	18	19	20	21	22	23
5-р сар	24	25	26	27	28	29	30
5,6-р сар	31	1	2	3	4	5	6
6-р сар	7	8	9	10	11	12	13
6-р сар	Мониторингийн эхний сарын дунг тайлганах	14	15	16	17	18	19
6-р сар	Мониторингийн долоо хоногийн дундийн мэдээлэл	21	22	23	24	25	26 Мониторинг дүүсах
6,7-р сар	28	29	30	1	2	3	27 Сонгуулийн өдөр
7-р сар	5	6	7	8	9	10	11
7-р сар	12	13	14	15	16	17	18

■ - Мониторинг хийх хугацаа

## СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН АЖИГЛАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Нэр дэвшүүгчийн нэр:

2. Намны нэр:

Агаа хамсэний төрөл: Уулзарт (У), Урлагийн тогтолц (УТ), Семинир, сургалт (СС), Сурталчилганы материйн тэрвэлт (СМТ) – Агаа хамсэний төрлийн гэмдэлтээдээ хөвгүйн уу.

Он сар өдөр	Байршил Үзүүлэлт	Үргэлжилсэн хугацаа	Оролцогчийн тоо		Баримтуулсан байдал Хальсыны дугаар
			Нэр дэвшүүгч, төрийн албан хаанч	Ирээд	
		1. Чингүй <input checked="" type="checkbox"/> Үнэгүй 2. Төгбөртэй <input checked="" type="checkbox"/> Төгбөртэй 3. Мэдэж, чадвагүй <input checked="" type="checkbox"/> Мэдэж чадвагүй	Нэр дэвшүүгч - Албан хаанчид -		

Төрийн албан хаагчийн кампанит эхийнд оролцсон байдал

Төрийн увааг кампанит эхийнд ашигласан байдал

1. Кампанит эхийнд оролцсон төрийн албан хаагчдын нэрс, албан тушаалт	2. Кампанит эхийнд эзриуулсан хувьцаа	1. Машины дугаар, марк	2. Агаа хамсэний үеэр яласан зам [км]
1.		1.	
2.		2.	
3.		3.	
4.		4.	
5.		5.	
6.		6.	
7.		7.	

Кампанит эхийн соотносон иргэд:

- 1.
- 2.

Ажиглалт хийсэн хүчиний нэр, гарынч чад:

## TV МОНИТОРИНГ

Телевизийн нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Монголын парламентийн сонгууль  
Мониторинг: 2004.4.26 -6.27  
Долоо хоногийн Н мэдээ

Төлбөртэй сургалчилгээ, минутаар		Далд сургалчилгээ, минутаар	
MAXH	Эх орон – Ардчилал эвсэн	Бусад нам, эвсан	Бие даан нэр жэвшилийн
Чөхүүнхүүлэх тараас голиттор, талбадартай настайан.			
1	Avgataad	Mongolpojirinhuu joroos xoholjinni	
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
Бүгд			

TV ДАЛД СУРТАЛЧИЛГААНЫ ШАЛГУУРУУДЫН ДАВТАМЖ

Телевизийн нэр: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Махчин жил	Эх орон-Ардчилал эвсэл			Бусад нам, эвсэл			Бие даан нэр дэвшигчид		
	A	B	C	A	B	C	A	B	C
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
Бүгд									

Долоо хоногийн дунг нэгтгэсэн:

Огноо: 2004 он \_\_ сар \_\_ өдөр

Төслийн багийн гишүүний гарын үсэг

## РАДИО Мониторинг

Радиогийн нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Монголын парламентны сонгууль  
Мониторинг: 2004.4.26 -6.27  
Даллас хөнөгийн мэдээ

Нэвтрүүлийн нэр:	Өрсөлдөгчийн талаар бодлой, тэнцвэртэй мэдээлэл	Төлбөртэй сурталчилгаа		Далд сурталчилгаа	Тайлбар:
		Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт		
?	Сонирхож буй мэдээлэл, сурталчилгааг шүүд хийсэн эсвэл түүний дотроо агулсан	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	1. СЕХ-ны хувваарийн дагуу явлагсан сурталчилгаа төлбөртэйд тооцогдоно. Ийм сурталчилгааг "СЕХ" гэж тайлбарлана байсан бол А, В, С -гээс давамгайлсан 1-3 шалгуур
		Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	2. Далд байсан бол А, В, С -гээс давамгайлсан шалгуур
				Дэхижүүлж жүүрээний шалгаруулалт	3. Бусад онцлог тохиолдол

Мониторинг хийсэн:

Огноо: 2004 он\_\_сар\_\_ өдөр

Төслийн багийн гишүүний гарын үсэг

СОННИН Мониторинг  
Огноо: \_\_\_\_\_  
Соннины нэр: \_\_\_\_\_

Монголын парламентийн сонгууль  
Далдоо хоногийн №6/3  
Ээж

Бүрд	Мониторингийн зорилт хөтөлбөрийн нийтийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>	Төлөртэй сурталчилгаа, талбай дм <sup>2</sup>	MAXH		Далд сурталчилгаа, талбай дм <sup>2</sup>		Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
			MAXH	Эх одон- адарчилан эвсэн	Бусад нам, эвсэн	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>	
1	МОНГОЛЫН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
2	МАЛДААН, ТАРДААН ДМ <sup>3</sup>	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
3	СОННИЙН ГӨРӨНӨЛӨЛ ТАРААГДЫН ТАРДААНДЫН ХААНЧИЛГАА, ТАЛБАЙ ДМ <sup>2</sup>	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
4	СОННИН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
5	СОННИН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
6	СОННИН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
7	СОННИН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>
8	СОННИН НАРОО ХОНОГИЙН АДАРЧИЛАН	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	Bycaal	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	CEX-HRI XYBAAPNIH JARLY BARATCACH	MAXH	Бие дахь хөд дэвшилийн талаар түүхийн хаанчилгаа, талбай дм <sup>2</sup>

## СОНИН ДАЛД СУРТАЛЧИЛГААНЫ ШАЛГУУРУУДЫН ДАВТАМЖ

Сонини нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

MAXH Mönhköpphüliniin tövöröö xohoriniiin tövöröö xohoriniiin	Эх орон-Ардчилал эвсэл			Бусад нам, эвсэл			Бие даан нэр дэвшүүгчид		
	A	B	C	A	B	C	A	B	C
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
Бүгд									

Долоо хоногийн дүнг нэлтгэсэн:

Огноо: 2004 он \_\_ сар \_\_ ийдээр

Төслийн багийн гишүүний гарын үсэг

